



МОНГОЛ УЛСЫН  
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 409

Улаанбаатар хот

Г

Г

Стандарт батлах тухай

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3 дахь хэсэг; Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2016 оны 12 дугаар сарын 01 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Хайгуул болон олборлох үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийн стандарт”-ыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

Хоёр. Тус стандартыг хайгуулын болон олборлох үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх, зохион байгуулалтын арга хэмжээ авахыг аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

Гурав. Энэ тушаалын хэрэгжилтэнд байнгын хяналт тавьж, ажиллахыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар / Б.Доржсэмбэд/-т үүрэг болгосугай.

Дөрөв. Энэ тушаал гарсантай холбогдуулан Сангийн сайдын 2011 оны 12 дугаар тушаалаар батлагдсан “Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын зардлыг нягтлан бодох бүртгэлд бүртгэх тухай” журмыг хүчингүй болсонд тооцсугай.



000962

Сангийн сайдын 2016 оны 409 тоот  
тушаалын 1 дүгээр хавсралт

## ХАЙГУУЛ БОЛОН ОЛБОРЛОХ УЙЛ АЖИЛЛАГААНЫ НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН СТАНДАРТ

## АГУУЛГА

### НЭГ. ЗОРИЛГО

#### ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

2.1 Уул уурхайн үйл ажиллагаа

2.2 Хайгуул болон Олборлох үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлд ашиглагддаг гол стандартуудын хураангуй

### ГУРАВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

#### ДӨРӨВ. ХАЙГУУЛ БОЛОН ОЛБОРЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ

4.1 I үе шат: Хайгуулын өмнөх – Урьдчилсан тандалт судалгаа

4.1.1 Үйл ажиллагааны хамрах хүрээ

4.1.2 Нягтлан бодох бүртгэл

1. II ба III үе шат: Хайгуул ба Үнэлгээний үе шат

4.2.1 Үйл ажиллагааны хамрах хүрээ

4.2.2. Нягтлан бодох бүртгэл

4.2.2.1 СТОУС 6 ашиглах

4.2.2.2 СТОУС 6 нь ашиглагдахгүй заалт

4.2.2.3 Хайгуул ба үнэлгээний холбоотой гарсан зардлыг НББ-д тусгах

4.2.2.4 Хайгуул үнэлгээний хөрөнгийн бүртгэл

4.2.2.5 Хайгуул үнэлгээний хөрөнгийн дахин ангилаал

4.2.2.6 Хайгуул ба үнэлгээний үе шатанд үүссэн хөрөнгийг элэгдуулэх

4.2.2.7 Илрүүлсэн нөөцөд тулгуурлан цаашид ашиглах эсэхийг тогтоох

4.2.2.8 Тайлагнал ба тодруулга

4.3 IV үе шат: Уурхай хөгжүүлэлт ба Бүтээн байгуулалтын үе шат

4.3.1 Үйл ажиллагааны хамрах хүрээ

4.3.2 Нягтлан бодох бүртгэл

4.3.2.1 Уурхайн хөгжүүлэлт ба Бүтээн байгуулалтын зардлын бүртгэл

4.3.2.2 Үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа

4.3.2.3 Элэгдэл ба хорогдол

4.3.2.2 Хүдрийн нөөцийн тооцоололыг тодорхойлох

4.3.2.5 Зээлийн өргөт

4.3.2.6 Үйлдвэрийг ашиглалтад оруулах туршилтын үйлдвэрлэлийн борлуулалт

4.3.2.7 Уурхайн хөгжүүлэлт ба Бүтээн байгуулалтын үе шатанд гарсан хөрс хуулалтын зардал

4.3.2.8 Тайлагнал ба тодруулга

4.4 V үе шат: Олборлолт ба Үйлдвэрлэлийн үе шат

4.4.1 Үйл ажиллагааны хамрах хүрээ

4.4.2 Нягтлан бодох бүртгэл

4.4.2.1 Үйлдвэрлэлийн үе шат хэзээ эхлэх вэ?

- 4.4.2.2. Олборлолт ба Үйлдвэрлэлийн шатанд гарсан ажил гүйлгээний холбогдох журналын бичилт
- 4.4.2.3 Үйлдвэрлэлийн үе шатны хөрс хуулалтын зардал
- 4.4.2.4 Хөрөнгийн засвар ба угсралтын зардал
- 4.4.2.5 Олборлолт ба үйлдвэрлэлийн шатанд хийгдсэн хайгуулын зардал
- 4.4.2.6 Бараа материал
- 4.4.2.7 Бараа материалын үнэ цэнийн бууралт
- 4.4.2.8 Орлого
- 4.4.2.9 Тайлагнал ба тодруулга

#### 4.5 VI үе шат: Уурхайг хаах болон Нөхөн сэргээх үе шат

- 4.5.1 Үйл ажиллагааны хамрах хүрээ
- 4.5.2 Нягтлан бодох бүртгэл
  - 4.5.2.1 Уурхайн хаалт ба нөхөн сэргээлтэд зориулан нөөц сан байгуулах
  - 4.5.2.2 Уурхайн хаалт ба нөхөн сэргээлтийн нөөцийн өөрчлөлт
  - 4.5.2.3 Уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн итгэлцлийн сан
  - 4.5.2.4 Нөхөн олговор
  - 4.5.2.5 Ажиллагсдын тэтгэвэр, тэтгэмж
  - 4.5.2.6 НББ-ийн бодлогын ба тооцооллын өөрчлөлт

### ТАВ. ТАЙЛБАР, ЖИШЭЭ

### ЗУРГАА. ХАВСРАЛТ

ХАВСРАЛТ 1 - Хайгуул болон Олборлох үйл ажиллагаа эрхэлдэг компаниудад мөрдөх дансны үлгэрчилсэн жагсаалт

### ДОЛОО. ТОВЧИЛСОН НЭР ТОМЬЁО

## НЭГ. ЗОРИЛГО

1. Энэхүү стандарт нь Хайгуул болон Олборлох салбарыг үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн Хайгуул болон Олборлох үйл ажиллагааны үе шатуудын хүрээнд үүссэн ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд бүртгэж, тайлгнах аргазүйг тодорхойлно.
2. Энэхүү стандартыг Санхүүгийн Тайлгналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу тус салбарын онцлогт тохируулан боловсруулсан ба ажил гүйлгээг татварын зорилгоор хэрхэн бүртгэлд тусгах тухай багтаагүй болно. Мөн “Газрын тос, байгалийн хийн олборлолт”-ын үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэл хамаарахгүй
3. Хэрэв энэ стандартын аль нэг заалт нь НББОУСХ-оос гаргасан СТОУС-тай зөрчилдвэл СТОУС-ыг мөрдөнө.

## ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1. Уул уурхайн үйл ажиллагаа нь ашиг олох зорилгоор ашигт малтмалын нөөц бүхий гэж таамагласан газарт хайгуул болон үнэлгээ хийн олборлолт болон үйлдвэрлэл явуулах зорилгоор бүтээн байгуулалт гүйцэтгэн үйлдвэрлэл явуулж бүтээгдэхүүнийг борлуулах үйл явцыг хамарна.
  - 2.1.1. Уул уурхайн үйл ажиллагааг дараах үндсэн үе шатуудад хуваан үзнэ. Үүнд:
    - I үе шат: Хайгуулын өмнөх үе шат - Урьдчилсан тандалт судалгаа
    - II үе шат: Хайгуулын үе шат
    - III үе шат: Үнэлгээний үе шат
    - IV үе шат: Уурхайн хөгжүүлэлт ба Бүтээн байгуулалтын үе шат
    - V үе шат: Олборлолт ба Үйлдвэрлэлийн үе шат
    - VI үе шат: Уурхайн хаалт ба Нөхөн сэргээлтийн үе шат
- 2.2. Хайгуул болон Олборлох салбарын нягтлан бодох бүртгэлд ашиглагддаг гол стандартуудын хураангуй:

№	Нэр	Агуулга
СТОУС 6	Ашигт малтмалын нөөцийн хайгуул ба үнэлгээний	Ашигт малтмалын нөөцийн хайгуул ба үнэлгээний хувьд санхүүгийн тайлгналыг тодорхойлох ба хүлээн зөвшөөрсөн аливаа хайгуул ба үнэлгээний хөрөнгөөс олох ирээдүйн мөнгөн урсгалын дүн, хугацаа ба боломжийг олгоход нь санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд туслах үүднээс нэмэлт тодруулга хийх удирдамжаар хангана.
СТОУСТХТ 20	Үйлдвэрлэлийн үе шат дахь хөрс хуулалтын зардал – Ил уурхай	Энэхүү стандарт нь ил уурхайн олборлолт болон үйлдвэрлэлийн шатанд хуримтлагдах уурхайн хаягдал зайлцуулах (хөрс хуулалтын) зарцуудыг хэрхэн санхүүгийн тайланд тусгах, тодруулах удирдамжаар хангана.
НББОУС 2	Бараа материал	Бараа материалыг бүртгэх бүртгэлийн аргыг тодорхойлно. Энэ стандарт нь бараа материалын өртгийг тодорхойлох, ингэхдээ цэвэр боломжит үнэ цэнэ хүртэл нь бууруулах бичилтийг оролцуулан түүнийг дараагийн үеүдэд хэрхэн хулээн зөвшөөрөх удирдамжаар хангана.
НББОУС 11	Барилгын Гэрээ (Урт хугацаат)	Барилгын Гэрээ (Урт хугацаат гэрээ)-нд хамаарах

	гэрээ)	гэрээний орлого, зардлыг дэлгэрэнгүй орлогын тайланд хэрхэн орлого, зардлаар хүлээн зөвшөөрөх тухай нягтлан бодох бүртгэлийн хандлагыг тодорхойлно.
НББОУС 16	Үндсэн хөрөнгө	Энэхүү стандарт санхүүгийн тайлан хэрэглэгчид аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалт болон хөрөнгө оруулалтын өөрчлөлт, үндсэн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт, тэдгээрийн дансны үнэ ба хүлээн зөвшөөрсөн холбогдох элэгдлийн дүн болон үнэ цэнийн бууралтын гарзыг тодорхойлно;
НББОУС 17	Түрээс	Түрээстэй холбоотойгоор түрээслэгч болон түрээслүүлэгчийн хэрэглэхэд зохистой нягтлан бодох бүртгэлийн бодлого, тодруулгыг зааварчилна.
НББОУС 18	Орлого	Санхүүгийн тайланг бэлтгэх, толилуулах үзэл баримтлалд хувьцаа эзэмшигчдийн оруулах хувь нэмэртэй ямар нэгэн холбоогүйгээр, хөрөнгө өсөх, эсвэл өр төлбөр буурах хэлбэрээр аж ахуйн нэгжийн эзэмшигчдийн өмчийг нэмэгдүүлэхэд хүргэсэн тайлант үеийн эдийн застгийн өгөөжийн өсөлтийг орлого гэж үзнэ. Энэ стандарт нь тодорхой ажил гүйлгээ, үйл явдлын үр дүнд үссэн орлогыг бүртгэх аргачлалыг тодорхойлно.
НББОУС 21	Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн үр нөлөө	Аж ахуйн нэгжийн гадаад валютаарх ажил гүйлгээ болон гадаад үйл ажиллагааг санхүүгийн тайланд хэрхэн тусгах болон санхүүгийн тайланг хэрхэн толилуулгын валют руу хөрвүүлэхийг тодорхойлно.
НББОУС 23	Зээлийн өртөг	Бэлтгэл шаардагдах хөрөнгийн худалдан авалт, барилгын ажил эсвэл үйлдвэрлэлтэй шууд хамааралтай зээлийн өртгийг тухайн хөрөнгийн өртгийн хэсэг болгоно. Бусад зээлийн өртгийг зардал гэж хүлээн зөвшөөрнө.
НББОУС 32	Санхүүгийн хэрэглүүр: Толилуулга	Санхүүгийн хэрэглүүрийг өр төлбөр эсвэл өмчөөр толилуулах болон санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийг нэгтгэж цэвэр дүнг гаргах зарчмыг тогтооно.
НББОУС 36	Хөрөнгийн үнэ цэнийн бууралт	Хөрөнгийн нөхөгдөх дүнгээс илүүгүй дүнгээр тусгах нөхцлийг баталгаажуулахад аж ахуйн нэгжийн мөрдөх горимыг тодорхойлно.
НББОУС 37	Нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө	Энэхүү стандартын гол зорилго нь нөөц, болзошгүй өр төлбөр болон болзошгүй хөрөнгийг хүлээн зөвшөөрөх хамгийн тохиромжтой шалгуур ба хэмжилтийн суурийг ашигласан бөгөөд тэдгээрийн мөн чанар, цаг хугацаа ба дүнг хэрэглэгчдэд ойлгомжтой байлагах хангалттай мэдээллийг тодруулсан гэдгийг харуулна.
НББОУС 38	Биет бус хөрөнгө	Тусгайласан шалгуурыг хангасан үед л биет бус хөрөнгийг хүлээн зөвшөөрөх, мөн биет бус

		хөрөнгийн дансны үнийг хэрхэн хэмжих, хэрхэн тодруулах тухай тайлбарлана. НББОУС 38 Биет бус хөрөнгө нь Хайгуул ба Үнэлгээний хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтэнд хэрэглэгдэхгүй.
НББОУС 39	Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба Хэмжилт	Санхүүгийн өр төлбөр ба санхүүгийн бус зүйлсийг худалдан авах, худалдах зарим гэрээг хүлээн зөвшөөрч, хэмжих зарчмуудыг тогтооно.
СТОУС 3	Бизнесийн нэгдэл	Бизнесийн нэгдэл, түүний үр дагаварын талаар тухайн аж ахуйн нэгж санхүүгийн тайландаа тусгасан мэдээллийн хамааралтай, найдвартай, зэрэгцүүлэгдэх байдлыг сайжруулахыг тодорхойлно.
СТОУСТХ 5	Хөрөнгийг ашиглалтаас гаргах болон Байгаль орчны нөхөн сэргээлтэд зориулан байгуулсан сангаас ашиглах эрх	Аж ахуйн нэгж хөрөнгийг ашиглалтаас гаргах, сэргээн засварлах эсвэл нөхөн сэргээх зардал гарах үед зориулан сан байгуулдаг. СТОУСТХ 5 нь байгуулсан санд хувь нийлүүлэгчийн бүртгэлийг болон хувь нийлүүлэгч нь санг нэмэх тохиолдолд хэрхэн бүртгэлд тусгах тухай тодорхойлно.
СТОУСТХ 1	Хөрөнгийг ашиглалтаас хасах, нөхөн сэргээх болон хүлээсэн байгаа бусад үүргүүдтэй холбоотой өр төлбөрийн өөрчлөлт	Хөрөнгийг ашиглалтаас хасах, нөхөн сэргээх болон хүлээсэн байгаа үүргүүдтэй холбоотой өр төлбөрийг хүлээн зөвшөөрч бүртгэсний дараа тухайн хүлээн зөвшөөрсөн тооцоолол өөрчлөгдөх, хөнгөлөлтийн хувийн өөрчлөлтөөс хамаарч өөрчлөгдсөн өр төлбөрийн өөрчлөлтийг бүртгэлд тусгах тухай тодорхойлсон.

## ГУРАВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

3.1. Энэхүү стандартын хувьд дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

*Ашигт малтмалын хөрөнгө(mining asset):* Хайгуул, олборлолт хийх зорилгоор газрын хөрсөн доорх ашигт малтмалыг хайх, олборлохтой холбоотой олж эзэмшсэн хөрөнгө юм. Ашигт малтмалын хөрөнгөнд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл, уурхай эрхлэх эрх, өөрийн хөрөнгөөр бий болгосон хөрөнгө (тоног төхөөрөмж, дэд бүтэц), олборлолтын эрх зэрэг биет болон биет бус хөрөнгийг оруулна.

*Ашигт малтмалын хөрөнгийн ангилал(classification of mining asset):* Ашиглагдаагүй/идэвхгүй (dormant) хөрөнгө, хайгуулын хөрөнгө, хөгжүүлэлтийн хөрөнгө, үйлдвэрлэлийн хөрөнгө эсвэл ажиллагаагүй хөрөнгө (defunct) гэж ангилана.

*Хайгуул ба үнэлгээний хөрөнгө (exploration and evaluation asset)* –ААН-ийн НББ-ийн бодлогын дагуу хөрөнгөөр хүлээн зөвшөөрөгддөг хайгуул ба үнэлгээний зардал

*Хайгуул ба үнэлгээний зардал (exploration and evaluation expense)* -Хайгуул хийх эрх авснаас хойш уг ордын ашигт малтмалын нөөц ашиглах боломжийг техник эдийн засгийн судалгаагаар тогтоох хүртэл гарч байгаа ашигт малтмалын хайгуул ба үнэлгээний зардал

*Ашигт малтмалын нөөцийн хайгуул ба үнэлгээ(exploration and evaluation of mineral resource)-* ашигт малтмал, газрын тос, байгалийн хий гэх мэт нөхөгдөхгүй нөөцийн тодорхой нэг чиглэлээр хайгуул хийх хууль эрх зүйн зөвшөөрөл авснаас хойш ашигт малтмалын нөөц олборлолтын техник эдийн засгийн үндэслэл ба арилжааны үр ашгийг тодорхойлох үеийн үйл ажиллагаа.

*Дансны үнэ(carrying value)* гэдэг нь аливаа хуримтлагдсан элэгдэл (хорогдол) ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассаны дараах хөрөнгийн хулээн зөвшөөрөх дүн

*Мөнгө бий болгогч нэгж(cash generating asset)* гэдэг нь бусад хөрөнгө буюу хөрөнгийн бүлгээс орох мөнгөн орлогын урсгалаас хамааралтай мөнгөн орлого үүсгэгч хөрөнгийн хамгийн бага бүлэг

*Нөхөгдөх дүн(recoverable value)* гэдэг нь хөрөнгө эсвэл мөнгө бий болгогч нэгжийн борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнэ ба ашиглалтын үнэ цэнийн алъ ихээр илэрхийлэгдэх дүн

*Ашиглалтын үнэ цэнэ(value in use)* гэдэг нь хөрөнгө эсвэл мөнгө бий болгогч нэгжээс үүсэхээр хүлээгдэж буй ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ.

*Нөөц(provision)* - Нөөц гэдэг нь цаг хугацаа эсвэл дүнгийн хувьд тодорхой бус өр төлбөр юм

*Хариуцлага үүсгэх үйл явдал(obligating event)* - Хариуцлага үүсгэх үйл явдал гэдэг нь аж ахуйн нэгж үүргийг биелүүлэхээс татгалзах боломжгүй хуулийн эсвэл үүсмэл хариуцлага юм

*Хуулиар хүлээсэн үүрэг хариуцлага(legal obligation)* - Хуулиар хүлээсэн үүрэг хариуцлага гэдэг нь аж ахуйн нэгжийн гэрээ (илэрхий эсвэл далд утгатай нөхцөлөөр), Хууль тогтоомж; эсвэл Хуулийн бусад үйл ажиллагааны үр дүнд үүссэн үүрэг хариуцлага юм

*Үүсмэл хариуцлага(constructive obligation)*- Үүсмэл хариуцлага гэдэг нь аж ахуйн нэгжийн дараах үйлдлийн үр дүнд үүссэн үүрэг хариуцлага юм:өнгөрсөн туршилага дээр үндэслэн авч хэрэгжүүлсэн үйлдэл, батлагдсан бодлого болон хангалттай хэмжээнд маш тодорхой хийгдсэн

мэдэгдэл зэргээр дамжуулан аж ахуйн нэгж нь бусад этгээдэд тодорхой үүрэг хариуцлага хүлээн авахаа амласан ба үүний үр дүнд уг аж ахуйн нэгж бусад этгээдийн өмнө үүрэг хариуцлага хүлээх хүчин төгөлдөр хүлээлтийг үүсгэсэн

*Цэвэр боломжит үнэ цэнэ*(*net realizable value*) – бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад борлуулахаар тооцсон үнээс түүнийг иж бурдэл болгохоор тооцсон зардал ба борлуулахад шаардагдах тооцсон зардлыг хассан дүн

*Бодит үнэ цэнэ*(*fair value*) – хэмжилтийн өдрөөр арилжаанд оролцогч талуудын хооронд хөрөнгийг борлуулснаар хүлээн авах буюу өр төлбөрөөр тооцож болох дүн.

## ДӨРӨВ. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ

### 4.1. I ҮЕ ШАТ. ХАЙГУУЛЫН ӨМНӨХ ҮЕ ШАТ – УРЬДЧИЛСАН ТАНДАЛТ СУДАЛГАА

#### 4.1.1. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ:

Хайгуулын өмнөх буюу урьдчилсан тандалт судалгааны үе шатанд ашигт малтмал байх магадлал бүхий геологийн хэвийн бус тогтоц, бүтээгдэх газар болон бусад сонирхол татах газруудад геологийн болон геофизикийн урьдчилсан туршилт, судалгааг хийнэ. Тандалт судалгааны үр дүнд олж илрүүлсэн анхан шатны мэдээлэлд үндэслэн тухайн газарт нөөц байгаа эсэх нь тодорхой байвал аж ахуйн нэгж нь цаашид хайгуул болон судалгааг үргэлжлүүлэн хийх хууль ёсны эрх авч хайгуулын үе шатанд шилжинэ.

#### 4.1.2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ:

4.1.2.1. Хайгуулын өмнөх буюу урьдчилсан тандалт судалгааны үе шатанд гарсан *урьдчилсан тандалт судалгаатай холбоотой зардлуудыг НББОУС 16 Үндсэн хөрөнгө стандарт, НББОУС 38 Биет бус хөрөнгө стандартуудад тодорхойлсон шаардлагатай нийцэж байвал хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Дараах өрөнхий шаардлага байна. (Дэлгэрэнгүйг НББОУС 16, НББОУС 38-аас харах)*

- (i) Хөрөнгийн тодорхойлолт нь: аж ахуйн нэгжийн өнгөрсөн үйл ажиллагааны үр дүнд бий болсон бөгөөд ирээдүйн эдийн засгийн үр өгөөж өгөхөөр хүлээгдэж байгаа бол,
- (ii)Хөрөнгийг хүлээн зөвшөөрөх шалгуур нь: хэрэв тухайн хөрөнгөтэй холбоотой эдийн засгийн үр өгөөжийг аж ахуйн нэгж хүртэх магадлалтай, мөн хөрөнгийн өргтийг бодитойгоор хэмжих боломжтой бол,

Холбогдох журналын бичилт:

Дт: Холбогдох биет хөрөнгө/ биет бус хөрөнгө .....xxxx

Кт: Мөнгөн хөрөнгө/ Өр төлбөр .....xxxx

4.1.2.2. Дээрхээс бусад тохиолдолд урьдчилсан тандалт судалгаатай холбоотой зардлуудыг тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрч дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана.

Холбогдох журналын бичилт:

Дт: Зардлын данс .....xxxx

Кт: Мөнгөн хөрөнгө/ Өр төлбөр .....xxxx

## 4.2. II БА III YE ШАТ. ХАЙГУУЛ БА ҮНЭЛГЭЭНИЙ YE ШАТ

### 4.2.1. УЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ:

*Хайгуулын ye шат* –Хайгуул гэдэг нь ашиг олох зорилгоор олборлож болохуйц ашигт малтмалын нөөцийг хайх үйл ажиллагаа бөгөөд урьдчилсан тандалт судалгааны үр дүнд үндэслэн үргэлжлүүлэн хайх ба сонгосон талбай, бусад ашигт малтмалын орд байгаа эсэхийг нарийвчлан тодорхойлдог.

Хайгуулын үйл ажиллагаа нь хайгуул хийх хууль ёсны эрх (хайгуулын лиценз) авснаар эхэлнэ. Хайгуулын талбайг тогтоох, тухайн газарт хайгуул хийсэн түүхэн мэдээ баримтыг олж судлан дэлгэрэнгүй дун шинжилгээ хийх; чичирхийллийн судалгаа, геологийн судалгаа, зураглал хийх, топографийн, геохимийн болон геофизикийн судалгаа шинжилгээ хийх; хайгуулын өрөмдлөг /баганат, цохилтот/, суваг татах болон дээж авах, сорьцолт малтталт хийх үйл ажиллагаа хамаарна (үүгээр хязгаарлагдахгүй). Мөн хайгуул хийх лицензийн худалдан авалт, бэлтгэл ажил /төлөвлөгөө зохиох, сансрын АСФЗ-ын тайлал/; эрлийн маршрут; гидрогеологийн ажил; топогеодезийн ажил; уулын ажил /копуш нэвтрэлт, шурф нэвтрэлт, булалт/, лабораторийн ажил; суурин боловсруулалт орно.

*Үнэлгээний ye шат* –Хайгуулын үндсэн дээр ашигт малтмалын тухайн орд газрын баттай эсвэл бодитой нөөцийг тодорхойлсон техник эдийн засгийн үндэслэлийг бэлтгэх, үнэлгээг хийх үйл ажиллагааг хэлнэ. Нөөц олборлолтын техник эдийн засгийн үнэлгээ хийхэд нөөцийн хэмжээ болон чанарыг үнэлэх, олборлолтын арга болон металтургийн эсвэл баяжуулалтын процессыг судлах, тээвэрлэлт болон дэд бүтцэд тавигдах шаардлагыг судлах, зах зээлийн болон санхүүгийн судалгаа, эдийн засгийн урьдчилсан судалгаа, нарийвчилсан өрөмдлөг, арилжааны чадамжийн судалгаа, чичирхийллийн үнэлгээ болон орд газрын хэмжээ, чанарыг тодорхойлох бусад төрлийн судалгаа, олборлолтын аргыг шалгаж турших ажлууд, эцэслэсэн ТЭЗҮ, хөрөнгө оруулах шийдвэр зэрэг хамаарна (үүгээр хязгаарлагдахгүй). Тооцоологдсон нөөцэд тулгуурлан тус орд газрын эдийн засгийн үр өгөөжийг тооцох ба тооцооллын үр дүнд ашигтай байх тохиолдолд цаашид уурхай барьж байгуулах, олборлолт явуулах эсэхийг удирдлага шийднэ.

Хайгуулын ye шат болон Үнэлгээний ye шатыг ихэвчлэн хамтад нь авч үздэг бөгөөд нягтлан бодох бүртгэлд заавал тусад нь салган бүртгэх шаардлагагүй.

### 4.2.2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ

4.2.2.1. Аж ахуйн нэгж ашигт малтмалын нөөцийн хайгуул ба үнэлгээтэй холбоотой гарсан зардлуудыг НББОУС 16 Үндсэн хөрөнгө стандарт, НББОУС 38 Биет бус хөрөнгө стандартуудад тодорхойлсон шаардлагатай нийцэж байвал хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Үүнээс бусад хайгуул ба үнэлгээтэй холбоотой гарсан зардлыг СТОУС 6 “Ашигт малтмалын нөөцийн хайгуул, үнэлгээ” стандартад нийцүүлэн **тусгай зөвшөөрөл бүрээр** НББ-дээ хөрөнгөөр бүртгэх, эсвэл зардал гарсан үед ашиг/алдагдлаар хүлээн зөвшөөрч бүртгэх гэсэн аргуудаас аль нэгийг нь сонгон нягтлан бодох бүртгэлийн бодлогоо тодорхойлно. НББ-ийн бодлогыг тайлант үеүдэд тогтвортой мөрдөнө.

#### 4.2.2.2. СТОУС 6 нь дараах зардлуудын хувьд ашиглагдахгүй

- Тодорхой орд газарт судалгаа хийх болон хайгуулын лиценз, болон хууль ёсны эрхийг авахын өмнөх зардлууд;
- Техник эдийн засгийн үнэлгээг хийж орд газар дахь нөөцийн арилжааны үр ашгийг бодитоор илэрхийлэгдэхүйц болсноос хойш гарсан зардлуудын хувьд уг стандартыг ашиглахгүй. Тухайлбал ашигт малтмалын нөөцийг ашиглах, боловсруулахад гарсан зардлыг энэ стандартад хамааруулахгүй.

#### 4.2.2.3. ХАЙГУУЛ БА ҮНЭЛГЭЭНИЙ YE ШАТАНД ГАРСАН ЗАРДЛЫГ НББ-Д ТУСГАХ

#### 4.2.2.3.1. Зардлыг балансад хуримтлуулан (капиталжуулан) хөрөнгөөр бүртгэх

Нягтлан бодох бүртгэлийн бодлогодоо хайгуул ба үнэлгээтэй холбоотой гарсан зардлыг балансад хуримтлуулан бүртгэх буюу **капиталжуулах\*** аргыг сонгосон бол тайлант үеийн зардлыг “Хайгуул, үнэлгээний хөрөнгө” дансанд бүртгэн санхүүгийн байдлын тайлангийн эргэлтийн бус хөрөнгийн хэсэгт тайлагнана. Хайгуул, үнэлгээний хөрөнгийг **өртгөөр** нь бүртгэнэ.

Холбогдох журналын бичилт:

Дт: Хайгуул үнэлгээний Хөрөнгө .....xxxx

Кт: Мөнгөн хөрөнгө/Өр төлбөр .....xxxx

Дараах аргуудаас сонгон НББ-ийн бодлогодоо тусгана.

- (i) амжилттай оролдлогын төрлийн арга (successful efforts type method) - энэ аргачлалд уурхайн нөөцийг илрүүлэх, олж эзэмших, эсвэл хөгжүүлэхтэй шууд холбогдон гарсан зардлуудыг ашигт малтмалын нөөц бүхий талбай тус бүрээр нөөц илэрсэн үеээс эхлэн капиталжуулна. Хэрэв нөөц илрээгүй, мөн нөөц илрэхээс өмнөх зардлуудыг гарах тухай бүрт нь Дэлгэрэнгүй орлогын тайландаа зардлаар тусгана.
- (ii) сонирхлын хүрээний арга (area of interest) – энэ аргачлалд ашигт малтмалын нөөц бүхий бие даасан геологийн талбайгаар зардлыг хуримтлуулан бүртгэнэ. Өөрөөр хэлбэл ашигт малтмалын нөөц байж болох газруудаа тодорхой хилээр зааглан зардлын төвийг тогтоох ба холбоотой гарсан бүх зардлуудыг эхнээс нь капиталжуулах ба гарсан зардлууд нь тухайн талбайг ашиглах, амжилттай хайгуул хийх эсвэл борлуулах тохиолдолд нөхөгдөхөөр хүлээгдэж байгаа болно. Бусад талбайн зардлыг тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрнө.

#### 4.2.2.3.2. Зардал гарсан үед ашиг/алдагдлаар хүлээн зөвшөөрч бүртгэх

Хэрэв nyaгтлан бодох бүртгэлийн бодлогодоо хайгуул ба үнэлгээтэй холбоотой гарсан зардлыг “зардлаар” хүлээн зөвшөөрнө гэж тусгасан бол тухайн тайлант үеийн “Хайгуулын зардал” дансанд бүртгэн дэлгэрэнгүй орлогын тайлангийн Үйл ажиллагааны зардлын хэсэгт тайлагнана.

Холбогдох журналын бичилт:

Дт: Хайгуулын зардал .....xxxx

Кт: Мөнгөн хөрөнгө/Өр төлбөр .....xxxx

#### 4.2.2.4. ХАЙГУУЛ ҮНЭЛГЭЭНИЙ ХӨРӨНГӨ

##### 4.2.2.4.1. Хайгуул үнэлгээний хөрөнгийн бүртгэл:

Хайгуул ба Үнэлгээний үе шатанд гарсан зардлуудыг анхлан НББ-д тусгахдаа шинж чанараас нь хамааруулан НББОУС 16 Үндсэн хөрөнгө стандарт, НББОУС 38 Биет бус хөрөнгө стандартуудад тодорхойлсон шаардлагатай нийцэж байвал холбогдох хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Эдгээр шаардлагуудад хамаараагүй Хайгуул ба Үнэлгээтэй холбоотой гарсан зардлуудыг капиталжуулах аргын үед хайгуул үнэлгээний хөрөнгө дансанд бүртгэн санхүүгийн байдлын тайландаа биет бус хөрөнгийн хэсэгт тайлагнана.

Жишээ нь өрөмдлөг хийх эрхийг биет бус хөрөнгөөр, тээврийн хэрэгсэл ба өрмийн тоног төхөөрөмжийг биет хөрөнгөөр ангилна. Биет бус хөрөнгө боловсруулахад биет хөрөнгийг ашиглаж байвал ашигласан дүнг биет бус хөрөнгийн өртгийн нэг хэсэг гэж үзнэ. Гэхдээ, биет бус хөрөнгө боловсруулахад биет хөрөнгийг ашиглаж байгаа нь тухайн биет хөрөнгө биет бус хөрөнгө болон өөрчлөгдж байгаа хэрэг биш юм.

##### 4.2.2.4.2. Хайгуул, үнэлгээний хөрөнгөнд хуримтлуулан бүртгэх зарим зардлууд:

\* Аливаа зардлыг капиталжуулахын тулд тухайн зардал нь байгууллагын хувьд ирээдүйн ямар нэг үр өгөөжтэй байх зарчмыг баримтална.

Аж ахуйн нэгж ямар зардлуудыг хайгуул үнэлгээний хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх тухай нягтлан бодох бүртгэлийн бодлогодоо тодорхойлох ба, уг бодлогоо цаашид тууштай мөрдөнө. /НББОУС 8-д заасан санхүүгийн тайлангийн мэдээллийн хамааралтай ба үнэн зөв, найдвартай байх зарчмуудыг баримтална./

1. Хайгуул ба Үнэлгээний үе шаттай холбоотой гарсан шууд зардлууд:

Хайгуул ба Үнэлгээний үе шаттай холбоотой гарсан шууд зардлуудыг Хайгуул үнэлгээний хөрөнгөнд капиталжуулан бүртгэнэ. Тухайлбал: Хайгуул ба Үнэлгээний үе шатанд дурдсан Бэлтгэл ажил /Төлөвлөгөө зохиох, Сансын АСФЗ-ын тайлал/, геологийн зураглал, эрлийн маршрут, талбайн сорьцлолт, геохимийн судалгаа, геофизикийн судалгаа, гидрогеологийн ажил, геоморфологийн ажил, топогеодезийн ажил, уулын ажил /копуш нэвтрэлт, шурф нэвтрэлт, булалт/, өрөмдлөг /баганат, цохилтот/, сорьцлолт /шурфын шлих/, лабораторийн ажил, муурин боловсруулалт, малталь хийх, дээж авах, мөн хайгуул ба үнэлгээтэй шууд хамааралтай ажилчдын тэтгэмж ,ашигласан материал, шатахуун, судалгаа болон өрөмдлөгийн зардал, гэрээт талуудад төлсөн төлбөр холбоотой гэх мэт үйл ажиллагаатай холбоотой зардлууд.

2. Нийлмэл (томилолт гэх мэт) зардлыг хуваарилах

Хэд хэдэн хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшдэг бол нийлмэл гарсан зардлыг тусгай зөвшөөрөл бүрээр хуваарилан Хайгуул үнэлгээний хөрөнгөнд бүртгэнэ. Нийлмэл зардлыг хуваарилахдаа аж ахуйн нэгж өөрсдийн онцлогт тохирсон суурийг мөрдөх ба НББ-ийн бодлогод тусгана. Жишээлбэл: Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээгээр, хайгуулын зорилгоор өрөмдсөн тушуу метрээр, тухайн тусгай зөвшөөрөлтэй холбоотой гарсан зардалд хувь тэнцүүлэн хуваарилах гэх мэт.

3. Хайгуул үнэлгээний хөрөнгөнд бүртгэх ерөнхий удирдлагын зардал

Аж ахуйн нэгж ашигт малтмалын хайгуул ба үнэлгээтэй шууд холбоотой гарсан ерөнхий удирдлагын зардлыг хайгуул ба үнэлгээний хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэж болох ба нягтлан бодох бүртгэлийн бодлогодоо тусгана.

4. Зээлийн хүүгийн зардал

Ашигт малтмалын хайгуулын ажлын явцад бэлтгэл ажиллагаа, хугацаа шаардах хөрөнгөнд шууд хамааралтай авсан зээлийн зардлыг капиталжуулах ба НББОУС 23 “Зээлийн зардал”-стандартын дагуу бүртгэнэ.

5. Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардал

Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон орд газрын улсад төлсөн нөхөн төлбөрийн зардлыг Хайгуул, үнэлгээний хөрөнгөнд бүртгэнэ.

6. Хайгуулын тусгай зөвшөөрлийн бүртгэл

Хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрт тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйлчилгээний хөлс, тусгай зөвшөөрөл худалдаж авсан үнэ, тусгай зөвшөөрлийн төлбөр орох ба тусгай зөвшөөрөл бүрээр **Хайгуулын лиценз** дансанд бүртгэж санхүүгийн байдлын тайландаа. Биет бус хөрөнгөөр тайлагнана. Хайгуулын лиценз дансыг тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаагаар элэгдүүлэх ба байгуулсан хорогдлын дунгээр **Хайгуул үнэлгээний хөрөнгөнд капиталжуулна**.

Холбогдох журналын бичилт:

1.Хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр төлөх үеийн бүртгэл:

Дт: Биет бус хөрөнгө- Хайгуулын лиценз .....xxxx

Кт: Мөнгөн хөрөнгө/Өр төлбөр .....xxxx

2.Хайгуулын лиценз дансыг тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаагаар элэгдүүлэх үеийн бүртгэл:

Дт: Хайгуул үнэлгээний хөрөнгө .....xxxx

Кт: Биет бус хөрөнгө- Хайгуулын лиценз .....xxxx

Зарим тохиолдолд хайгуулын ажил нь хайгуулын лицензийн хугацаанаас өмнө дуусаж ашиглалтын лиценз авдаг. Энэ үед хайгуулын лицензийн хорогдуулж дуусаагүй үлдэгдлийг “Хайгуул үнэлгээний хөрөнгө” дансанд бүртгэнэ.

## 7. Хайгуулын үе шатны нөхөн сэргээлтийн бүртгэл

Хайгуул ба үнэлгээний үе шатны нөхөн сэргээл болон талбайг сэргээн засварлах, хог хаягдлыг зайлцуулах үүрэг хариуцлагыг НББОУС 37 “Нөөц, Болзошгүй Өр төлбөр ба Болзошгүй Хөрөнгө” стандартын дагуу хүлээн зөвшөөрнө.

### 4.2.2.4.3. Хайгуул үнэлгээний хөрөнгийг хүлээн зөвшөөрсний дараа үеийн хэмжилт:

Хайгуул ба үнэлгээний хөрөнгийг хүлээн зөвшөөрсний дараа байгууллага өртгийн загвар эсвэл дахин үнэлгээний загварын аль алиныг ашиглана. Хэрэв дахин үнэлгээний загварыг ашиглаж байгаа бол (НББОУС 16 Үндсэн хөрөнгө эсвэл НББОУС 38-д заасан загварын аль аль нь) уг стандартуудад заасан хөрөнгийн ангилалтай нийцэж байх ёстай.

(i) **Дахин үнэлгээний загвар:** Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсний дараа үндсэн хөрөнгийг түүний бодит үнэ цэнийг илтгэх дахин үнэлсэн дүнгээр хэмжих ба дахин үнэлсэн дүн нь дараа үеийн хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүн байна. Дансын үнэ ба бодит үнэ цэнийн хооронд материаллаг зөрүү гаргахгүй байх үүдиэс тайлагналын үеийн эцэс бүрт дахин үнэлгээг хийнэ. (Илүү дэлгэрэнгүйг 4.6.1 бүлгээс харах)

(ii) **Өртгийн загвар:** Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсний дараа үндсэн хөрөнгийг хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан өртгөөр нь үнэлэх ёстай.

### 4.2.2.4.4. Хайгуул үнэлгээний хөрөнгийн үнэ цэнийн бууралт:

Хайгуул ба Үнэлгээний хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг бодит нөхцөл байдлууд нь хөрөнгийн дансны үнэ нь тэдгээрийн нөхөгдөх дүнгээс хэтэрсэн байж болзошгүйг илтгэж байвал уг хөрөнгөнд үнэ цэнийн бууралт бий болсон эсэхийг үнэлнэ. Үнэ цэнэ нь буурсан байж болзошгүй хөрөнгийг илрүүлэх шалгалтыг хамгийн багадаа жилд нэг удаа хийх ба шалгалтын давтамжийг аж ахуйн нэгж нягтлан бодох бүртгэлийн бодлогоороо тодорхойлно. Хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдлыг НББОУС 36 Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт стандартын дагуу бүртгэнэ.

#### 1. Үнэ цэнийн бууралт байгаа эсэхийг шалгах:

Дор дурдсан бодит нөхцөл байдлуудаас нэг эсвэл хэд хэдэн нөхцөл биелбэл Хайгуул үнэлгээний хөрөнгөнд үнэ цэнийн бууралтын шалгалт хийнэ. (энэ жагсаалтаар хязгаарлагдахгүй) Үүнд:

1. Тухайн газар нутагт хайгуул хийх эрхийн хугацаа нь хайгуулын явцад дууссан эсвэл ойрын хугацаанд дуусах бөгөөд дахин шинэчлэгдэх боломжгүй, хугацааг сунгахаар төлөвлөгөөгүй;
2. Тухайн газар нутагт цаашид ашигт малтмалын Хайгуул ба Үнэлгээний ажлыг үргэлжлүүлэн хийх томоохон зардлууд нь төсөв болон төлөвлөгөөнд тусгагдаагүй;
3. Тухайн газар нутагт хийсэн ашигт малтмалын хайгуул болон үнэлгээгээр арилжааны үр ашиг өгөхүйц хэмжээний ашигт малтмалын нөөцийг илрүүлээгүй тул байгууллагын зүгээс тухайн газарт хийх үйл ажиллагааг зогсоохоор шийдсэн;
4. Тухайн газар нутагт боловсруулах үйл ажиллагаа үргэлжлэх боломжтой боловч тухайн уурхайг амжилттай ашигласнаар эсвэл борлуулалтаас хайгуул ба үнэлгээний хөрөнгийн дансны үнийг бүрэн нөхөгдөх магадлал байхгүй гэдгийг харуулах хангалттай тоон мэдээ байгаа
5. Бүтээгдэхүүний үнэ буурах эсвэл үйлдвэрлэлийн зардал өсөх;
6. Засгийн газрын зүгээс байгаль орчны хуулийг шинээр батлах, үнэ бүрдэлтийн зохицуулалт хийх болон татварыг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээ авах.

7. Стандартад заасан дээрх нөхцөлөөс гадна бүртгэлийн бодлогодоо тодорхойлсон өөр шалгуурыг авч үзэж болно.

8. Үнэ цэнийн бууралтын алдагдлыг буцаах:

Хамгийн сүүлд үнэ цэнийн гарзыг хүлээн зөвшөөрснөөс хойш хөрөнгийн нөхөгдөх дүнг тодорхойлоход хэрэглэсэн тооцоололд өөрчлөлт орсон бол өмнөх үед хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарзыг буцаана. Үнэ цэнийн алдагдлын гарзыг буцаасны улмаас өсөх хөрөнгийн дансны үнэ нь үнэ цэнийн бууралт хүлээн зөвшөөрөгүй байх үеийн дансны үнээс хэтрэх ёсгүй.

НББОУС 36 Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт стандартын 109-123-р зүйлд заасан тусгай шаардлагуудад нийцж байгаа үед аж ахуйн нэгжийн бүх хөрөнгө (гүүдвил болон борлуулахад бэлэн гэж ангилсан өмчийн хөрөнгө оруулалтаас бусад)-ийн хувьд үнэ цэнийн бууралтын гарзыг буцаана.

Хэрэв хайгуул, үнэлгээний хөрөнгөнд үнэ цэнийн бууралт тооцсон эсвэл шалгалтаар үнэ цэнийн бууралт байхгүй бол хайгуул үнэлгээний хөрөнгийн дахин ангилал хийнэ.

4.2.2.5. Хайгуул үнэлгээний хөрөнгийн дахин ангилал:

Ашигт малтмалын нөөцийг олборлох техник эдийн засгийн үнэлгээ ба арилжааны үр ашиг нь тодорхой болсон, тухайн ордыг арилжааны зорилгоор ашиглах шийдвэр гарсан үед Хайгуул үнэлгээний хөрөнгийг **Уурхайн хөрөнгөөр** шилжүүлэн бүртгэнэ.

Холбогдох журналын бичилт:

Дт: Уул уурхайн хөрөнгө .....xxxx

Кт: Хайгуул үнэлгээний хөрөнгө .....xxxx

4.2.2.6. Хайгуул ба үнэлгээний үе шатанд үүссэн хөрөнгийг элэгдүүлэхдээ:

- (i) Биет бус хөрөнгөөр ангилагдсан хөрөнгүүдийг ашиглагдах хугацаагаар нь хорогдол байгуулан Хайгуул үнэлгээний хөрөнгөд бүртгэнэ.
- (ii) Биет хөрөнгө (тухайлбал машин, тоног төхөөрөмж гэх мэт)-ийг ашиглалтын хугацаанд элэгдүүлэн Хайгуул үнэлгээний хөрөнгөд бүртгэнэ.
- (iii) Хайгуул үнэлгээний хөрөнгө дансыг элэгдүүлэхгүй.

4.2.2.7. ИЛРҮҮЛСЭН НӨӨЦӨД ТУЛГУУРЛАН ЦААШИД АШИГЛАХ ЭСЭХИЙГ ТОГТООХ:

4.2.2.7.1. Ашигт малтмалын нөөцийн техник эдийн засгийн үнэлгээ ба арилжааны үр ашигт үндэслэн үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлэх эсэхийг удирдлага шийдвэрлэнэ. Хэрэв тухайн нэг лицензийн эсвэл нийтэд нь хайгуулын ажлыг зогсоох шийдвэр гаргавал хуримтлуулан бүртгэсэн **Хайгуул, үнэлгээний хөрөнгийг** тухайн тайлант үеийн алдагдлаар хүлээн зөвшөөрч **Хайгуулын зардал** дансанд хааж дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана.

Холбогдох журналын бичилт:

Дт: Хайгуулын зардал .....xxxx

Кт: Хайгуул үнэлгээний хөрөнгө .....xxxx

4.2.2.7.2. Хэрэв тайлагналын өдрөөр бүртгэгдсэн хайгуулын төсөл нь тухайн тайлант өдрийн дараа хийгдсэн өрөмдлөгийн үйл ажиллагаагаар олж илрүүлсэн баримт нотолгооны үр дүнд амжилтгүй болох нь тогтоогдвол энэ үйл явдлыг санхүүгийн тайланд тодруулна. Үүнийг НББОУС 10 “Тайлагналын үеийн дараах үйл явдал” стандартын дагуу зохицуулна. Тус стандартаар санхүүгийн тайланг залруулах, болон үл залруулах буюу тодруулах үйл явдлыг тодорхойлсон. Үүнд:

- а. Тайлагналын өдөр бодитоор оршин байсан нөхцөл хэвээрээ байгааг нотлох үйл явдал - тайлагналын өдрийн дараах залруулагдах үйл явдал буюу санхүүгийн

тайланг залруулах, өөрөөр хэлбэл залруулга хийх шаардлагатай үйл явдлууд гэдэгт тайлагналын хугацааны эцэст тухайн нөхцөл үүссэнийг нотлох баримт, нотолгоо байгаа үйл явдлууд хамаарна.

- b. Тайлагналын өдрийн дараа үүссэн нөхцлийг илэрхийлэх үйл явдал – тайлагналын өдрийн дараах үл залруулагдах үйл явдал буюу санхүүгийн тайланда тодруулах, өөрөөр хэлбэл нөхцөл байдал нь тайланг тасалбар болгосноос хойш буюу тайланг бэлтгэсний дараа үүссэн бол тухайн үйл явдал нь залруулга хийх шаардлагагүй нөхцөл байдалд хамаарна.

#### 4.2.2.8. ТАЙЛАГНАЛ БА ТОДРУУЛГА:

Аж ахуйн нэгж санхүүгийн тайландаа хүлээн зөвшөөрсөн ашигт малтмалын хайгуул ба үнэлгээтэй холбоотой дүнг тодорхойлж, тайлбарласан нэмэлт тодруулга хийнэ.  
Үүнд:

- a) Хайгуул, үнэлгээний хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт болон түүний зарцуулалтын талаарх нягтлан бодох бүртгэлийн бодлого;
- б) Ашигт малтмалын нөөцийн хайгуул, үнэлгээтэй холбоотой бий болсон хөрөнгө, өр төлбөр, орлого ба зардал, үйл ажиллагааны ба хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээний дүн;
- в) Хайгуул, үнэлгээний хөрөнгийг тусдаа хөрөнгийн ангилалд тусгах бөгөөд НББОУС 16 эсвэл НББОУС 38-д шаардсаны дагуу тэдгээр хөрөнгийг хэрхэн ангилсан тухай тодруулга;
- г) Бусад холбоотой стандарт шаардлагуудын дагуу тодруулга хийх;

#### 4.3. IV ҮЕ ШАТ. УУРХАЙН ХӨГЖҮҮЛЭЛТ БА БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ҮЕ ШАТ

##### 4.3.1. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ:

Уурхай хөгжүүлэлт ба Бүтээн байгуулалтын үе шатанд техник эдийн засгийн үнэлгээ дууссан эсэх, удирдлага уурхайн хөгжүүлэлт ба бүтээн байгуулалтын үе шатыг эхлүүлэх шийдвэр гаргасан үесэх эхлэн шилжсэн гэж үзнэ. Уурхайн хөгжүүлэлт ба бүтээн байгуулалтын үе шатанд орд газраас нөөцийг олборлох, баяжуулах болон эцсийн бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд шаардлагатай дэд бүтэц, үйлдвэрлэлийн байгууламжийг барих, машин тоног төхөөрөмж суурилуулах, болон үйлдвэрлэлийг явулахад шаардлагатай бусад бэлтгэл ажлууд хамаарна. Мөн үндсэн нөөцөд хүрэх далд уурхайн малталт; уурхайд зам болон туннель барих; хөрс болон хаягдал чулууг урьдчилан зайлуулах, уурхайн барилга байгууламж, уурхайд ажилчдын байрлах тосгоныг бүтээн байгуулах, ажилчдын сургалт зэрэг ажлууд хийгддэг байна.

##### 4.3.2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ:

Уурхайн төслийн эдийн засгийн үр ашигтай байдал нь тогтоогдсон цагаас эхлэн ашигт малтмалын нөөцийг арилжааны зориулалтаар үйлдвэрлэлд оруулахад шаардагдах бүтээн босголт, дэд бүтэц болон уурхайг ашиглалтад бэлтгэхтэй холбогдон гарсан зардлуудыг капиталжуулна.

##### 4.3.2.1. УУРХАЙН ХӨГЖҮҮЛЭЛТ БА БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ҮЕ ШАТАНД ГАРСАН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ЗАРДЛЫН БҮРТГЭЛ

- i. Уурхайг бүтээн босгох үе шатанд үндсэн хөрөнгийн томоохон худалдан авалтууд хийгддэг бөгөөд НББОУС 16 Үндсэн хөрөнгө стандартыг дагуу бүртгэлд тусгана.
- ii. Уурхайг бүтээн босгох үе шатанд хийгдэж буй дэд бүтцийн зардлуудыг *бий болгож буй биет хөрөнгийн ангиллын* дагуу Дуусаагүй барилга дансанд хуримтлуулан бүртгэнэ. Дуусаагүй барилга дансанд хөрөнгийн ангиллын дагуу туслах дансыг нээж болно.

Дт: Дуусаагүй барилга .....xxxx

Кт: Мөнгө/ Өр төлбөр .....xxxx

- iii. Хөрөнгийг **ашиглахад бэлэн** болсон үед Дуусаагүй барилга данснаас холбогдох биет хөрөнгө (барилга байгууламж, тоног төхөөрөмж гэх мэт)-өөр ангилах ба хөрөнгийг элэгдүүлнэ:

Дт: Холбогдох үндсэн хөрөнгө .....xxxx

Кт: Дуусаагүй барилга .....xxxx

- iv. Ашиглалтын лицензийн төлбөрийг олборлох үе шат хүртэл **Уул уурхайн хөрөнгө** дансанд капиталжуулан бүртгэнэ.

Дт: Уул уурхайн хөрөнгө .....xxxx

Кт: Мөнгө/ Өр төлбөр .....xxxx

Олборлох үе шатанд төлсөн ашиглалтын лицензийн төлбөрийг бүтээгдэхүүний өртөгт бүртгэнэ.

##### 4.3.2.2. ҮНДСЭН ХӨРӨНГИЙН АШИГЛАХ ХУГАЦАА:

Үндсэн хөрөнгийн ашиглах хугацааг НББОУС 16 Үндсэн хөрөнгө стандартыг дагаж мөрдөх ба тооцоолол нь ижил төстэй хөрөнгийг ашигласан жилийн туршлага, удирдлагын үнэлэлт, хөрөнгөд агуулагдсан ирээдүйд олох эдийн засгийн үр өгөөж дээр үндэслэнэ. Хөрөнгийн ашиглагдах хугацааг дараах шаардлагад үндэслэн тооцоолно (НББОУС 16).

- (i) хөрөнгийн ашиглагдах боломжтой хугацаа; эсвэл
- (ii) тухайн хөрөнгийг ашиглаад бий болгох бүтээгдэхүүн үйлчилгээний тоо хэмжээ, түүнтэй адилтгах зүйлсийн нэгж байна

Ихэнх тохиолдолд хөрөнгийн эдийн засгийн үр өгөөж нь техникийн хоцрогдол болон элэгдэл хуучралт зэрэг бусад хүчин зүйлээс шалтгаалан хөрөнгө сул зогссоны улмаас буурдаг. Иймд хөрөнгийн ашиглалтын хугацааг тодорхойлохдоо дараах хүчин зүйлсийг харгалzan үзнэ.

1. аж ахуйн нэгжийн хүлээгдэж буй хөрөнгийн ашиглалтын хэмжээ. Ашиглалтын хэмжээг хөрөнгийн хүлээгдэж буй хүчин чадал буюу бодит гарцтай холбож үнэлнэ,
2. ашиглах хөрөнгийн ээлжийн тоо, аж ахуйн нэгжийн засвар үйлчилгээний хөтөлбөр болон хөрөнгө сул зогсолтод байх үеийн засварын ажиллагаа зэрэг үйл ажиллагааны хүчин зүйлсээс хамаарах хүлээгдэж буй биет элэгдэл, хуучралт,
3. үйлдвэрлэлд өөрчлөлт буюу сайжруулалт хийгдсэнээс эсвэл тухайн хөрөнгийг ашиглаж үйлдвэрлэдэг бүтээгдэхүүний буюу үйлчилгээний гарцын зах зээлийн эрэлтэд өөрчлөлт гарсны улмаас үүссэн техникийн хоцрогдол; холбогдох түрээсийн ашиглалтын хугацаа дуусах зэрэг хөрөнгийн ашиглалттай холбоотой хууль эрх зүйн эсвэл түүнтэй адилтгах эрхийн хязгаарлалт зэргийг харгалзан тооцно.

#### 4.3.2.3. ЭЛЭГДЭЛ БА ХОРОГДОЛ:

Үндсэн хөрөнгийн элэгдлийг НББОУС 16 Үндсэн хөрөнгө стандартыг дагаж мөрдөнө. Элэгдлийн арга, элэгдүүлэх хугацааг НББ-д бодлогод тусгана.

Уул уурхайн хөрөнгүүдийг НББ-ийн зорилгоор олон улсын практикт дараах байдлаар элэгдүүлж болно. Гэхдээ ААН-үүд өөрсдийн туршлага, уурхайн онцлогт үндэслэж болно.

Хөрөнгийн ангилал	Ашиглалтын хугацаа жилээр:
Өөрөө явагч тоног төхөөрөмжүүд	5 -7 жил
Бусад тоног төхөөрөмж	1 -10 жил
Уурхайн зам, ажилчдын байр зэрэг уурхайд ашиглагдаж байгаа байшин барилгууд,	5 -20 жил
Тавилга, эд хогшил, тээврийн хэрэгсэл болон компьютер	3-5 жил
Дуусаагүй барилга	Элэгдэхгүй
Ашигт малтмалын хөрөнгө (Уул уурхайн хөрөнгө, хөрс хуулалтын хойшлуулсан зардал, баяжуулах үйлдвэр, бусад тоног төхөөрөмж)	Эдийн засгийн хувьд ашигтай нөөцийн тоо хэмжээнд үндэслэн бүтээгдэхүүний нэгжид ногдуулах аргаар

#### 4.3.2.4. ХҮДРИЙН НӨӨЦИЙН ТООЦООЛЛЫГ ТОДОРХОЙЛОХ:

Мэргэшсэн мэргэжилтнүүд нөөцийн тооцооллыг хийх ба тооцоолын бодитой байдал нь ашигт малтмалын үнэ, үйл ажиллагааны зардал, уурхайн төлөвлөгөө болон уурхайн ашиглалтын хугацаа, ашигт малтмалын чанар, олборлолт, валютын ханш, инфляци, хүчин зүйлүүдийн нөлөөллийг агуулж байдаг. Нөөцийн тооцоолол нь ашигт малтмалын хөрөнгийн хорогдол тооцох, үнэ цэнийн бууралтын зардлыг тооцох, уурхайн хөрс хуулалтыг бүртгэх, уурхайг хаах, нөхөн сэргээх болон ижил төстэй зардлын төлбөрийг төлөх хугацааны баримжааллыг тооцох болон бусад төстэй зардлуудыг тооцоход ашиглагддаг. Тиймээс ашиглаж болох нөөцийн тооцоололд нөлөөлсөн таамаглал, хүчин зүйлүүд өөрчлөгдвэл энэ нь хөрөнгийн дансны үнэ, ашиг алдагдлын тайланд тусгагдсан хорогдуулгын зардал болон үнэ цэнийн бууралтын алдагдал, уурхайг хаах, нөхөн сэргээх болон түүнтэй ижил төстэй нөөцийн төлбөрийн өглөг зэрэгт нөлөө үзүүлнэ.

Хүдрийн нөөцийн тооцооллыг шинэ мэдээлэл, таамаглалууд гарч ирсэн үед дахин тооцоход хүргэж болно. Тухайлбал түүхий эдийн үнийн өөрчлөлт, валютын ханшийн өөрчлөлт, үйлдвэрлэлийн зардал эсвэл түүнийг нөхөн олох хувь зэргийн урьдчилсан таамаглалууд өөрчлөгдхөг гэх мэт

#### 4.3.2.5. ЗЭЭЛИЙН ӨРТӨГ:

Аж ахуйн нэгж нь зээлийн өртгийг НББОУС 23 Зээлийн өртөг стандартын дагуу тайлагнана. Бэлтгэл шаардах хөрөнгө буюу зориулалтын дагуу ашиглахад ихээхэн хэмжээний хугацаа зайлшгүй шаардагддаг хөрөнгийг олж бэлтгэх, барилгын ажил болон үйлдвэрлэлтэй шууд хамааралтай зээлийн өртгийг тухайн хөрөнгийн өртөгт капиталжуулна. Бусад зээлийн өртгийг зардалд бүртгэн тайлант үеийн ашиг алдагдалд тусгана.

1. Дараах нөхцлүүдийг бүгдийг нь хангасан өдрөөс эхлэн хүүг капиталжуулж эхэлнэ.
  - а) аж ахуйн нэгж бэлтгэл шаардах хөрөнгөнд зардал гаргасан,
  - б) зээлийн өртөг үүссэн болон,
  - в) хөрөнгийг зориулалтын дагуу ашиглахад бэлтгэх шаардлагатай үйл ажиллагааг эхлүүлсэн,
2. Зориулалтын дагуу ашиглах эсвэл борлуулах хөрөнгийг бэлтгэхэд шаардагдах бүх ажиллагаа дууссан үед зээлийн өртгийн капиталжуулалтыг зогсоно.
3. Бэлтгэл шаардагдах хөрөнгийн барилгын ажил хэсэгчлэн дууссан үед хэсэг бүрийг тухайн үед ашиглаж болох боловч бусад хэсгийн барилгын ажил үргэлжлэн хийгдэж байгаа үед зориулалтын дагуу ашиглах эсвэл борлуулах тэр хэсгийг бэлтгэхэд шаардагдах үндсэн ажиллагаа дууссан нөхцөлд зээлийн өртгийн капиталжуулалтыг зогсоох
4. Удирдлага уурхайн бүтээн байгуулалтыг түр зогсоох тухай шийдвэр гаргасан тохиолдолд хүүгийн капиталжуулалтыг түр зогсоож болох ба энэ үед хүүгийн зардлыг дэлгэрэнгүй орлогын тайланд санхүүгийн зардаар хүлээн зөвшөөрнө.
5. Капиталжуулах зээлийн өртгийн дүнг тооцоолоходо байгууллагын ерөнхий зээлийн жигнэсэн дундаж (бэлтгэл шаардах хөрөнгөнд зарцуулсан зардлыг жигнэсэн дундаж хүүгийн өртгөөр үржүүлэн гаргасан дүн) өртгийг ашиглан тооцоолно.

#### **4.3.2.6. ҮЙЛДВЭРИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ ХАГАС ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТУРШИЛТЫН ЯВЦ ДАХЬ БОРЛУУЛАЛТ**

Уул уурхайн салбарт үйлдвэрийг ашиглалтад бүрэн оруулах хугацаа нь ихэнхдээ 12-с дээш сар шаардлагатай байх тохиолдолууд байдаг бөгөөд үйлдвэрлэлийг аажмаар нэмэгдүүлж, төлөвлөсөн хүчин чадалд хүргэдэг.

Үйлдвэрийн шаардлагатай ашиглалтын нөхцлийг хангах хүртэл үйлдвэрлэсэн зүйлс (тоног төхөөрөмжийг шалгах үед үйлдвэрлэсэн дээж бүтээгдэхүүн)-ийг борлуулснаар олсон цэвэр орлогын дүнг тухайн хөрөнгийн эсвэл үйлдвэрийн өртөгт бүртгэнэ. [НББОУС 16 Үндсэн хөрөнгө 17(д) стандартын дагуу үндсэн хөрөнгийн хэвийн ажиллагааг шалгах зардлыг хөрөнгийн өртөгт хамааруулна].

Аж ахуйн нэгж уурхайг менежментийн төлөвлөсөн түвшинд ажиллах боломжтой байдалд хүргэх явцтай шууд холбоотойгоор борлуулах боломжтой материалын үйлдвэрлэсэн/олборлосон гэдгийг тодорхой нотолсон тохиолдолд ийнхүү хасаж болно. Хэрэв тодорхой харуулах боломжгүй бол ийм орлогыг (мөн борлуулах боломжтой материалыг үйлдвэрлэсэн зардлыг) дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана.

#### **4.3.2.7. УУРХАЙН ХӨГЖҮҮЛЭЛТ БА БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ҮЕ ШАТАНД ГАРСАН ХӨРС ХУУЛАЛТЫН ЗАРДАЛ**

Хүдрийн олборлолт эхлэхээс өмнө буюу уурхайн хөгжүүлэлт болон бүтээн байгуулалтын үе шатанд уурхайн талбайгаас шимт хөрс хуулах, хаягдал чулууг зайлзуулах гэх мэт нөөцөд хүрэхэд зориулан ихээхэн хэмжээний хөрс хуулалтыг хийж гүйцэтгэдэг. Энэхүү хөрс хуулалтын зардал нь нөөцийг олборлох болон уурхайн бүтээн байгуулалтад ирээдүйд эдийн засгийн нэмэлт үр ашиг бий болгоно гэж үзэж байгаа бол капиталжуулна.

Холбогдох журналын бичилт:

- (i) Уурхайн хөгжүүлэлт ба Бүтээн байгуулалтын үе шатанд гарсан хөрс хуулалтын үйл ажиллагааг гэрээт компаниар гүйцэтгүүлж байгаа үед гарсан зардлын хэмжээгээр

Уул уурхайн хөрөнгө дансанд бүртгэнэ. Уул уурхайн хөрөнгө дансанд Хөрс хуулалтын хөрөнгө гэсэн туслах данс нээж болно:

Дт: Уул уурхайн хөрөнгө – Хөрс хуулалтын хөрөнгө.....xxxx

Кт: Мөнгөн хөрөнгө/Өр төлбөр .....xxxx

(ii)Уурхайн хөгжүүлэлт ба Бүтээн байгуулалтын үе шатанд гарсан хөрс хуулалтын үйл ажиллагааг аж ахуйн нэгж өөрийн дотоод нөөцөөрөө гүйцэтгэж байгаа үед тухайн холбоотой гарсан зардлуудыг Уул уурхайн хөрөнгө дансанд бүртгэнэ:

Дт: Уул уурхайн хөрөнгө – Хөрс хуулалтын хөрөнгө.....xxxx

Кт: Өр төлбөр/Мөнгөн хөрөнгө .....xxxx

#### 4.3.2.8. ТАЙЛАГНАЛ БА ТОДРУУЛГА:

Аж ахуйн нэгж санхүүгийн тайландаа уурхай хөгжүүлэлт болон бүтээн босголтын үе шаттай холбоотой аливаа дүнг тодорхойлж, тайлбарласан нэмэлт тодруулга хийнэ. Үүнд:

- а) Нягтлан бодох бүртгэлийн бодлого журам болон элэгдэл/ хорогдлын талаархи журмууд;
- б) Капиталжуулсан бүтээн босголтын болон барилга угсралтын зардлын дүн;
- в) Арилжааны үйлдвэрлэлийн түвшинд хараахан хүрээгүй байгаа төслүүдийн капиталжуулалтын хэмжээ;
- г) Бусад холбоотой стандарт болон хуулийн шаардлагуудын дагуу тодруулга хийх;

## 4.4. V YE ШАТ. ОЛБОРЛОЛТ БА ҮЙЛДВЭРЛЭЛИЙН YE ШАТ

### 4.4.1. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ:

Олборлолт ба үйлдвэрлэлийн үе шатанд борлуулалтаас ашиг олохуйц хэмжээний бүтээгдэхүүнийг орд газраас олборлоход чиглэсэн өдөр тутмын үйл ажиллагаа явагдах бөгөөд олборлолт болон борлуулалтын өмнөх баяжуулах процесс, уурхайн ашиглалт болон ашигт малтмал боловсруулалтын үйл ажиллагаа хамаарна. Өөрөөр хэлбэл арилжааны зориулалтаар борлуулж болохуйц бүтээгдэхүүн үйлдвэрлэж, хэрэглэгчдэд хүргэх байнгын үйл ажиллагаа энэ үе шатанд хийгдэх ба түүнтэй холбоотой зардлууд элэгдэл, хорогдол, борлуулалтаас өмнөх тээвэрлэлт ижил төрлийн бусад зардлуудыг хамруулна.

### 4.4.2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ:

Уул уурхайн нягтлан бодох бүртгэлд уурхайг бүтээн босгох үе шат хэзээ дуусах, үйлдвэрлэлийн үе шат хэзээ эхлэхийг тасалбар болголт чухал. Хөрөнгийг ашиглах үеэс эхлэн хуримтлуулсан зардлыг Бүтээгдэхүүний нэгжид ногдох аргаар хорогдуулах ба мөн үйлдвэрлэлтэй холбоотой зардлуудыг үйлдвэрлэлийн өртөгт бүртгэнэ.

#### 4.4.2.1. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН YE ШАТ ХЭЗЭЭ ЭХЛЭХ ВЭ?

Үйлдвэрлэлийн үе шатанд шилжсэн гэдгийг тодорхойлох гол хүчин зүйл нь тухайн орд газрыг ашиглахад бэлэн болсон эсэх юм. Уул уурхайн компаниудын хувьд энэ нь ихэвчлэн үйлдвэрлэлийн гарц арилжааны түвшинд хүрэх хугацаа байдаг бөгөөд зарим тохиолдолд энэ хугацаа нь үйлдвэрлэлийн зарим техникийг ашиглалтад оруулах хугацаатай тэр бүр давхацдаггүй.

Үйлдвэрлэлийн гарц хэзээ арилжааны түвшинд хүрсэн бэ? гэдгийг тодорхойлохын тулд инженерүүд болон уул уурхайн мэргэжилтнүүд бүтээгдэхүүний тоон болон чанарын үзүүлэлтүүдийг харгалзан гаргасан мэдээлэлд үндэслэн арилжааны зориулалтаар үйлдвэрлэлийг эхлүүлэх эсэхийг удирдлага шийдвэрлэнэ. Дараах хүчин зүйлүүдийг харгалзана (үүгээр хязгаарлагдахгүй):

1. уурхайд ашиглагдах гол тоног төхөөрөмж, дэд бүтцийг ашиглалтанд оруулсан эсэх,
2. олборлолт, баяжуулалтын дараах бүтээгдэхүүний хэмжээ төлөвлөсөн хэмжээнд хүрсэн эсэх,
3. үйлдвэрлэлийг тасралтгүй явуулах буюу бүтээгдэхүүнийг тасралтгүй үйлдвэрлэх боломжтой болсон эсэх,
4. ашигт малтмалын олборлолт болон металл авалтын хэмжээ нь төлөвлөсөн хэмжээ эсвэл түүнтэй ойролцоо хэмжээнд хүрсэн эсэх,

Гадны хүчин зүйлийн улмаас бүтээн босголт удаан хугацаагаар саатах эсвэл үйлдвэрлэлийн хэмжээ урьдчилан тодорхойлсон арилжааны түвшинд хүрэхгүй байх зэрэг тохиолдлуудад дээрх хүчин зүйлсийг дахин тооцоолж шинэчлэх шаардлагатай.

Үндсэн нөөцөд хүрэх зориулалтаар хаягдлыг зайлцуулах явцад борлуулах боломжтой, бага чанартай ашигт малтмалыг гаргаж ирэхийг олборлолтын үйл явц эхэлсэнд тооцохгүй.

#### 4.4.2.2. ОЛБОРЛОЛТ БА ҮЙЛДВЭРЛЭЛИЙН YE ШАТАНД ГАРСАН ЗАРИМ АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ХОЛБОГДОХ ЖУРНАЛЫН БИЧИЛТ

1. Олборлолт ба бүтээн байгуулалтын үе шатнаас эхлэн **Уурхайн хөрөнгө** дансыг уурхайн ашиглалтын хугацаанд хорогдуулна.

Хорогдуулалтыг бүртгэхдээ:

Дт: Дуусаагүй үйлдвэрлэл .....xxxx

Кт: Уул уурхайн хөрөнгө .....xxxx

2. Ашиглалтын лицензийн төлбөрийг төлөх үеийн бүртгэл:

Дт: Дуусаагүй үйлдвэрлэл .....xxxx  
Кт: Мөнгөн хөрөнгө/Өр төлбөр .....xxxx

#### 4.4.2.3. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЕ ШАТНЫ ХӨРС ХУУЛАЛТЫН ЗАРДАЛ:

Үйлдвэрлэлийн үе шатанд хийгдэж байгаа хөрс хуулалт нь ихэвчлэн уурхайн амны периметрийг өсгөх, түүнтэй холбоотойгоор хаягдал чулуу зайлцуулах, уурхайн энгийн үйл ажиллагааны явцад үүссэн ихээхэн хэмжээний хаягдлыг уурхайн цооногоос зайлцуулах гэх мэт үйл ажиллагаанууд хамарна.

1. Хөрс хуулалтын зардлыг СТОУСТХ 20 Ил уурхай - Үйлдвэрлэлийн үе шат дахь хөрс хуулалтын зардал тайлбарын дагуу бүртгэж тайлагнана.
2. Хэрэв хөрс хуулалтаар бараа материал бий болсон, ойрын хугацаанд ил гаргасан хүдрийг олборлох бол НББОУС 2 Бараа материал стандартын дагуу материалын өртөгт бүртгэнэ.
3. Хэрэв хөрс хуулалтын үр дунд ирээдүйн олборлох нөөцөд нэвтрэх байвал хөрс хуулалтын зардлыг хойшлуулах ба СТОУСТХ 20-д зааснаар дараах шаардлагуудыг хангасан тохиолдолд хөрс хуулалтын зардлыг капиталжуулж бүртгэнэ. Үүнд:
  1. хөрс хуулалтын үйл ажиллагааны ирээдүйн үр өгөөжийг аж ахуйн нэгж хүртэх магадлалтай байх;
  2. нөөцөд нэвтрэх нөхцөл боломжийг сайжруулсан хүдрийн ордны орцыг тухайн аж ахуйн нэгж тодорхойлж чадаж байх;
  3. тухайн орцыг гаргаж авахтай холбоотой хөрс хуулалтын үйл ажиллагааны зардал нь баттай хэмжигдэхүйц байх.
4. Хөрс хуулалтын зардлыг хойшлуулахдаа инженерүүд болон уурхайн мэргэжилтнүүдийн дараах хүчин зүйлүүдийг харгалзан тооцоолсон хөрс хуулалтын харьцаа/коэффициентоор тооцно.
  1. үйлдвэрлэсэн бараа материалын өртгийг тооцоолсон өртөгт харицуулах,
  2. хуулсан хөрсний тоо хэмжээг тооцоолсон хүдрийн тоо хэмжээнд харицуулах,
  3. олборлосон хүдэр дэх эрдсийн агуулгын хэмжээг олборлосон хүдрээс олохоор тооцоолсон эрдсийн агууламжийн хэмжээнд харицуулна.

Холбогдох журналын бичилт:

1. Тайлант хугацаанд гарсан нийт хөрс хуулалтын зардлыг Дуусаагүй үйлдвэрлэл дансанд хуримтлуулан бүртгэнэ. Дуусаагүй үйлдвэрлэл дансны туслах дансуудыг зардлуудын нэр төрлөөр нь нээж болно.

Дт: Дуусаагүй үйлдвэрлэл .....xxxx

Кт: Мөнгөн хөрөнгө/Өр төлбөр .....xxxx

2. Хөрс хуулалтын зардлаас хойшлуулан бүртгэх дүнг тусгай коэффициентээр тооцоолон холбогдох Дуусаагүй үйлдвэрлэл данснаас **Уул уурхайн хөрөнгө** дансанд ангилан бүртгэх ба Уурхайн хөрөнгө дансанд туслах дансыг нээж болно.

Дт: Уул уурхайн хөрөнгө .....xxxx

Кт: Дуусаагүй үйлдвэрлэл.....xxxx

3. Хойшлуулсан хөрс хуулалтын зардлаас үүссэн Уул уурхайн хөрөнгө дансыг бүтээгдэхүүний нэгжид ногдуулах аргаар хорогдуулан Дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэнэ:

Дт: Дуусаагүй үйлдвэрлэл .....xxxx

Кт: Уул уурхайн хөрөнгө .....xxxx

Хөрс хуулалтын зардлыг уурхай тус бүрээр эсвэл хэд хэдэн уурхайг нэгтгэсэн хэлбэрээр бүртгэж болно. Тухайлбал бие даасан үйл ажиллагаа явуулах шаардлагатай, мөн хэд хэдэн ил уурхай хэлбэрээр олборлолт хийгддэг тохиолдолд уурхай тус бүрээр олборлож буй хүдрийн онцлогоос хамаарч хөрс хуулалтын зардлыг уурхай тус бүрээр бүртгэнэ. Хэрэв хоёр дахь болон дараагийн уурхайн ашиглалтын төлөвлөгөө нь тэдгээрийг нэгтгэн цогцоор гүйцэтгэх боломжоос ихээхэн

хамааралтай, мөн уурхайгаас олборлосон хүдрийг холих буюу хамтад нь боловсруулалт хийх боломжтой бол эдгээр уурхайнуудыг нэгдсэн үйл ажиллагаатай уурхай гэж үзнэ.

#### 4.4.2.4. ХӨРӨНГИЙН ЗАСВАР БА УГСРАЛТЫН ЗАРДАЛ

Уурхайн болон баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, үндсэн техникийн хэвийн үйл ажиллагааг хангах, хүлээгдээгүй эвдрэл сул зогсолтоос сэргийлэх, техникийн тогтвортой үйл ажиллагааг хангах, өндөр эрсдэлтэй уул уурхайн салбарын хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах үүднээс эд ангиудыг тодорхой хугацаагаар сольдог. Эдгээр ангиудыг үндсэн техникийн туслах хөрөнгө байдлаар бүртгэн, стандарт норм, мото-цаг эсвэл үйлдвэрлэгчээс зааварчилсан хугацаанд шулуун шугаман аргаар элэгдүүлнэ. Аж ахуй нэгжүүд өөрсдийн уурхайн онцлог, техникийн үзүүлэлтүүдэд үндэслэн НББ-ийн бодлогоороо тодорхойлно. Урсгал засвараар бага үнэ цэнэтэй, гэнэтийн эвдрэлд тэр бүр хүргээд байдаггүй, гарцаад нөлөөлдөггүй, хэвийн үйл ажиллагааг хангадаг, тодорхой богино хугацаанд солигддог эд ангиудыг тайлант жилийн зардалд тусгана.

Хөрөнгийг задлан газрыг чөлөөлж шинэ байршилд угсрах зардлыг НББОУС 16 Үндсэн Хөрөнгө стандартын дагуу тухайн үндсэн хөрөнгийн өртөгт бүртгэнэ. Хэрэв бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд тулгарсан шаардлагын улмаас уг хөрөнгийг задалж, өөр газар угсарсан бол үүнтэй холбогдох зардлыг НББОУС 2 Бараа материал стандартын дагуу бүртгэнэ.

#### 4.4.2.5. ОЛБОРЛОЛТ БА ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ШАТАНД ХИЙГДСЭН ХАЙГУУЛЫН ЗАРДАЛ

Олборлолт ба үйлдвэрлэл эхэлсний дараа ашигт малтмалын нөөцийг нэмэгдүүлэх, нөөцийг нарийвчлан тогтоох зорилгоор үргэлжлэн хийгдэж байгаа хайгуул, үнэлгээний зардал нь ирээдүйд хүчин чадлыг нэмэгдүүлэх магадлалтай бол тус хайгуулын ажлын зардлыг капиталжуулна.

Хэрэв хайгуулын үр дүнд ашигт малтмалын нөөцийг олборлох техник эдийн засгийн үнэлгээ өөрчлөгдөөгүй ба арилжааны үр ашиг нь тодорхой бус болсон нь нотлогдвол тайлант хугацааны алдагдлаар зөвшөөрнө.

#### 4.4.2.6. БАРАА МАТЕРИАЛ:

1. Бараа материалд бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад худалдан борлуулах, энэ борлуулалтын зорилгоор үйлдвэрлэлийн дамжлагад байгаа зүйлс болон хангамжийн зүйлс хэлбэрээр байгаа хөрөнгийг хамруулна. Бараа материалыг НББОУС 2 Бараа материал стандартын дагуу бүртгэнэ. Бараа материалыг 1-ээс илүү жил ашиглагдах, 1 жилийн дотор ашиглагдах гэж ангилан санхүүгийн тайланда тайлagnana. Бараа материалыг дараах байдлаар ангилна.
  1. сэлбэг хэрэгсэл
  2. хангамжийн материал,
  3. бэлэн бүтээгдэхүүн. – зэс, нүүрс, баяжуулсан бүтээгдэхүүн, (эдгээрээр хязгаарлагдахгүй),
  4. дуусаагүй үйлдвэрлэл - бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх явцад боловсруулж байгаа бараа материал бөгөөд үүнд буталсан хүдэр, хүдрийн овоолго, бага агуулгатай материал, хагас боловсруулсан бүтээгдэхүүн (эдгээрээр хязгаарлагдахгүй) зэргээс бүрдэнэ.
2. Бараа материалыг өртөг болон цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар нь үнэлэн тайлagnах ба өртөг болон цэвэр боломжит үнэ цэнийн аль нь бага байгаа эсэхийг тайлант үе бүрт шалгана. Хэрэв аливаа үнэ цэнийн бууралт үссэн бол тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрнө.

3. Бараа материалын өртгийг эхэлж авснаа эхэлж зарцуулах (ЭАЭЗ) эсвэл жинлэсэн дундаж өртгийн (ЖДӨА) аргаар тооцох ба ямар аргыг ашиглах тухай НББ-ийн бодлогодоо тусгана. Жинлэсэн дундаж өртгийн аргын үед тайлант үеийн эхэнд байсан ижил төрлийн бараа материал болон тайлант үеийн туршид үйлдвэрлэсэн, ижил төрлийн бараа материалын жинлэсэн дундаж өртгөөр нэгжийн өртгийг тодорхойлно.

#### 4.4.2.6.1. Бараа материалын өртөгт орох зардлууд:

1. Худалдан авалтын өртөгт худалдан авсан үнэ, гааль, импортын татвар, хураамжууд, тээвэрлэлт, ачиж буулгахтай холбоотой зардлууд, бүтээгдэхүүн, материал, үйлчилгээг худалдан авахтай шууд холбоотой бусад зардлууд, худалдааны хөнгөлөлт, урамшууллыг худалдан авалтын өртгөөс хасч тооцно. Тухайлбал сэлбэг хэрэгсэлийн өртгийг худалдан авалтын өртөг болон шууд холбогдож гарсан зардал буюу одоогийн байршил ба нөхцөлд авчрахтай холбоотой гарсан бүх зардлын дүнгээр бүртгэнэ.
2. Үйлдвэрлэлийн өртөгт материалыг бэлэн бүтээгдэхүүнд хувиргахтай холбоотой хөдөлмөр болон бусад зардал орно.
  - Шууд материал болон шууд хөдөлмөрийн зардал - хүдрийг олборлох, бутлах, угаах болон бэлэн бүтээгдэхүүнийг боловсруулахтай шууд холбоотой гарсан хөдөлмөр, материалын зардлууд,
  - Шууд бус зардал - шууд зардлуудаас бусад уурхайн олборлолт, үйлдвэрлэлтэй холбогдон гарсан бүх зардал, тухайлбал засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгсэл, үйлдвэрийн ажиллагсдын сургалтын зардал, үйлдвэрийн захиргаа ба удирдлагын цалин, мөн засварын ажилчдын цалин, үйлдвэрийн тоног төхөөрөмжийн элэгдэл, хөрс хуулалтын зардлаас хойшлуулсан хөрөнгийн хорогдол, уул уурхайн хөрөнгийн хорогдол, үйлдвэрлэлтэй холбогдсон түрээсийн зардал, мөн уурхайн дээр гарсан бусад нэмэгдэл зардлууд гэх мэт.

Холбогдох журналын бичилт:

Хүдрийг олборлох болон боловсруулахад гарсан шууд ба шууд бус зардал, уурхай дээр гарсан нэмэлт зардлуудыг Дуусаагүй үйлдвэрлэл дансанд хуримтуулан бүртгэнэ. Дуусаагүй үйлдвэрлэл дансанд туслах дансыг нээж болно:

Дт: Дуусаагүй үйлдвэрлэл .....xxxx

Кт: Мөнгө/Өр төлбөр .....xxxx

#### 4.4.2.6.2. Бараа материалын өртөгт орохгүй зардал

Бараа материалын өртөгт ордоггүй бөгөөд тайлант үеийн зардал гэж хүлээн зөвшөөрөгддөг зардлын жишээ:

1. Хаягдал материал, хөдөлмөр буюу үйлдвэрлэлийн бусад зардлын хэвийн бус дүн
2. Үйлдвэрлэлийн өмнөх дамжлагаас дараагийн шат дамжлага дунд зайлшгүй гарах зардлаас бусад хадгалалтын зардлууд
3. Бараа материалыг одоогийн байршил болон нөхцөлд авчрахтай холбогдож гарагүй удирдлагын нэмэгдэл зардал
4. Борлуулалтын зардал
5. Зээлийн зардал (НББОУС-23 Зээлийн өртөг-т бараа материалын өртөгт багтаадаг хязгаарлагдмал нөхцлийг тодорхойлсон)

#### 4.4.2.6.3. Бэлэн бүтээгдэхүүн –Үйлдвэрлэлээс бэлэн бүтээгдэхүүнийг агуулах руу шилжүүлэх үед үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртгийн хэмжээгээр бүртгэнэ.

Холбогдох журналын бичилт:

Дт: Бэлэн бүтээгдэхүүн .....xxxx

Кт: Дуусаагүй үйлдвэрлэл .....xxxx

4.4.2.6.4. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг – Бэлэн бүтээгдэхүүнийг борлуулах үед түүний дансны үнийг борлуулалтын орлогыг хүлээн зөвшөөрсөн тайлант хугацааны зардал гэж хүлээн зөвшөөрнө.

Холбогдох журналын бичилт:

Дт: Борлуулсан бүтээгдэхүүний өртөг .....xxxx

Кт: Бэлэн бүтээгдэхүүн .....xxxx

Хэрэв аж ахуйн нэгж нь бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн олон цех, дамжлагатай, нэгж цехүүд нь бие биедээ харилцан үйлчилгээ үзүүлдэг гэх мэт үйлдвэрлэлийн зардал болон бүтээгдэхүүний өргтийг тооцоолоход хүндрэлтэй бол нягтлан бодох бүртгэлийн стандарт өргтийг хэрэглэж болно. Практикт энэ төрлийн үйл ажиллагааг НББ-ийн сайн системээр автоматаар тооцоолол хийдэг байна. Стандарт өргтөөр бүртгэлийг хийж байгаа тохиолдолд гүйцэтгэл болон стандарт өргтийн зөрүү үүсэх ба зөрүүг Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт бүртгэнэ.

#### 4.4.2.7. БАРАА МАТЕРИАЛЫН ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТ

Бараа материалыг өртөг болон цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар нь тайлагнах ба үнэ цэнийн бууралт байгаа эсэхийг шалгана. Бараа материалын өргтийг цэвэр боломжит үнэ цэнэ хүртэл нь бууруулахдаа ихэвчлэн бараа тус бүрээр бууруулдаг боловч зарим тохиолдолд харилцан холбоотой бараа материалыг хамтад нь бүлэглэн бууруулна. Бараа материалыг ижил эцсийн хэрэглэгчтэй, ижил нутаг дэвсгэрт үйлдвэрлэгдэн борлуулагддаг, нэг үйлдвэрийн шугамд хамаардаг бөгөөд тэдгээрийг тухайн үйлдвэрлэлийн шугамын бусад бараа материалаас тусад нь үнэлэх боломжгүй бол бүлэглэнэ.

Бараа материалын үнэ цэнийн бууралт үүссэн үед дараах байдлаар бүртгэнэ:

Дт: Үнэ цэнийн бууралтын алдагдал .....xxxx

Кт: Бараа материалын үнэ цэнийн бууралтын нөөц/хасагдуулга .....xxxx

##### 4.4.2.7.1. Үнэ цэнийн бууралтын бичилтийг буцаах бүртгэл:

1. Бараа материалд үнэ цэнийн бууралтын алдагдлыг хүлээн зөвшөөрсөн шалтгаан, нөхцөл нь үгүй болсон, эсвэл эдийн засгийн нөхцөл байдлаас үүдэн цэвэр боломжит үнэ цэнэ өссөн бөгөөд энэ өсөлтийг тодорхой нотолж болохуйц бол үнэ цэнийн бууралтын алдагдлыг буцаана. Тухайлбал бараа материалын борлуулалтын үнэ буурсны улмаас цэвэр боломжит үнэ цэнэ буурсан бөгөөд дараагийн тайлант үед тухайн бараа материалын борлуулалтын үнэ өсвөл хорогдуулах бичилтийг буцаана. Үнэ цэнийн бууралтын бичилтийг буцаахдаа анх үнэ цэнийн бууралтыг бүртгэсэн бичилтийг буцаах ба ингэснээр дансны үнэ нь өртөг болон шинэчилсэн цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар тодорхойлогдоно.

2. Үнэ цэнийн бууралтын алдагдлыг буцаасан дун, мөн буцаалтын бичилтийг хийхэд хүргэсэн үйл явц болон нөхцөл байдлыг санхүүгийн тайланд тодруулна.

3. Тухайлбал нуруулдан уусгах дэвсгэр дээрх хүдрийн өргтийг цэвэр боломжит үнэ цэнийн бууралтаас шалтгаалан хорогдуулсан ба борлуулсан бүтээгдэхүүний өртөгт тусгасан. Үнэ цэнийн бууралтын шалтгаан нь үгүй болсон тул хорогдуулах бичилтийг буцаана.

Холбогдох журналын бичилт:

Дт: Бараа материалын үнэ цэнийн бууралтын нөөц .....xxxx

Кт: Үнэ цэнийн бууралтын алдагдал / ББӨ .....xxxx

#### 4.4.2.8. ОРЛОГО:

1. Бараа материалыг борлуулах, хүү, эрхийн төлбөр, ногдол ашиг бий болгогч хөрөнгөө бусдад ашиглуулах үед орлого олох ба 2018 оны 1 сарын 1-ний өдөр

2. Орлогыг хүлээн авсан эсвэл хүлээн авахаар хүлээгдэж буй төлбөрийг бодит үнэ цэнээр хэмжинэ. Өөрөөр хэлбэл орлогын дүнгээс хямдral, хөнгөлөлт, худалдааны татвар, барааны болон үйлчилгээний хураамж, НӨАТ гэх мэт гуравдагч талын өмнөөс цуглуулсан дүнг хасна.
3. Дараах шалгуурыг бүгдийг нь хангасан нөхцөлд борлуулалтын орлогыг хүлээн зөвшөөрнө. Үүнд:
  1. Бүтээгдэхүүний өмчлөлтэй холбогдон үүсэх нөлөө бүхий эрсдэл, өгөөжийг худалдан авагч талд шилжүүлсэн;
  2. Компани нь худалдсан барааны өмчлөлтэй ихэвчлэн холбогдон гардаг удирдлагын байнгын оролцооны болон үр ашигт хяналтын үүргийг аль алиныг нь өөртөө хадгалаагүй;
  3. Орлогын дүнг үнэн бодитой хэмжих боломжтой байгаа;
  4. Борлуулалттай холбогдон гарах эдийн засгийн өгөөжийг компани хүртэх магадлалтай байгаа;
  5. Борлуулалттай уялдан гарсан ба, эсвэл гарах зардлыг бодитойгоор хэмжин тодорхойлж болохоор байгаа.
6. Хөрөнгийн эрсдэл болон өмчлөлийг шилжүүлэх  
Олон улсын Худалдаа Аж Үйлдвэрийн тэнхимийн Олон улсын худалдааны гэрээний тухай журамд эрсдэл болон өмчлөлийг шилжүүлэх ойлголтыг тусгасан байдаг. Өргөнөөр ашиглагдаг олон улсын худалдааны нөхцлүүд нь:
  1. ФОБ-ачуулах цэг (FOB-free on board) нөхцөлтэйгөөр худалдан авсан бараа материал нь борлуулагч талаас ачигдаж гарсан бол өмчлөгчийн бүх эрх нь худалдан авагч талд шилжих тул худалдан авагч хэзээ хүлээн авах байсан ч уг бараа материалыг үлдэгдэл бараа материалын дүнд оруулж тооцно. Энэ үед тээврийн зардлыг худалдан авагч тал өөрөө хариуцна.
  2. ФОБ-хүрэх цэг Худалдан авагч барааг хүлээн авах хүртэл өмчлөлийн бүх эрх нь борлуулагч талд байх тул уг бараа материал нь борлуулагчийн бүртгэлд хэвээр байна. Энэ үед тээврийн зардлыг борлуулагч тал хариуцах бөгөөд үүнийг борлуулалтын зардалд оруулж тооцно.
  3. Өртөг, даатгал, тээвэр (“CIF”) нөхцөл - Тогтсон нэг цэгт хүргэх ба өмчлөлийг шилжүүлэхээс өмнөх эрсдэлийг борлуулагч хүлээнэ. Өөрөөр хэлбэл борлуулж буй уул уурхайн компани нь барааг худалдан авагчид хүргэх хүртэл тээвэр болон даатгалыг хариуцах ба худалдан авагчид хүргэх хүртэл үүсч болох эрсдэлийг хүлээхийн зэрэгцээ өмчлөлийн үр өгөөжийг хүртэх боломжтой болно. Иймд орлогыг хүлээн зөвшөөрөх хугацаа нь хүргэлтийн нөхцөлөөс хамааран өөр өөр байна.
7. Хэрэв аж ахуйн нэгж нь ачилт, даатгал, тээвэрлэлтийг хариуцаж байгаа бол худалдан авагчаас нэхэмжилсэн ачилтын болон тээвэрлэлтийн хөлсийг борлуулалтын орлого гэж ангилна. Аж ахуйн нэгжийн гаргасан ачилтын зардлыг үйл ажиллагааны зардал гэж хүлээн зөвшөөрнө.
8. Борлуулалтын үнийг гэрээний үнээр тооцно.
9. “Урьдчилсан үнэ”-тэй борлуулалтын гэрээ:  
Уул уурхайн үйлдвэрлэлийн бараа материал нь ихэвчлэн урт хугацаат гэрээгээр борлуулагдаг ба борлуулалтын үнэ нь Лондонгийн Металлын Бирж зэрэг идэвхтэй бөгөөд чөлөөтэй арилжаалагддаг зах зээлд тогтоогдсон үнэ дээр үндэслэсэн байдаг. Аж ахуйн нэгж “Урьдчилсан үнэ”-ээр үнэлэгддэг борлуулалтын гэрээ хийсэн тохиолдолд борлуулалтын орлогыг холбогдох зах зээлийн үнэд суурилсан, хүлээн

авах төлбөрийн бодит үнэ цэнийн тооцоололд үндэслэн хүлээн зөвшөөрнө. Өөрөөр хэлбэл бүтээгдэхүүнийг худалдан авагчид шилжүүлсэн хамгийн сайн тооцооллыг ашиглан борлуулалтын орлогыг урьдчилан тооцсон үнээр анх хүлээн зөвшөөрөх ба нэхэмжлэлүүдийн үнийн эцсийн залруулгыг заавал бүртгэх ба тайлант үеийн борлуулалтанд тусгана.

10. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тайлагнах:

Роялтиг тайлагнах: НББОУС 18 Орлого стандарт нь ногдуулсан роялтиг орлогоос хасаж цэвэр дүнгээр тайлагнах эсвэл тусад нь тайлагнах эсэхийг тодорхой тусгаагүй байдаг тул аж ахуйн нэгж НББ-ийн бодлогоор тодорхойлно. Ногдуулсан роялтигийн дүнг үйл ажиллагааны зардалд бүртгэнэ.

#### 4.4.2.9. ТАЙЛАГНАЛ БА ТОДРУУЛГА

Аж ахуйн нэгж санхүүгийн тайландаа олборлолт ба үйлдвэрлэлийн үе шаттай холбоотой аливаа дүнг тодорхойлж, тайлбарласан нэмэлт тодруулга хийнэ. Үүнд:

- а) Бараа материалын ашигласан өргтгийн томъёолол, бараа материалыг хэмжихэд баримталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого;
- б) Орлогыг хүлээн зөвшөөрөх баримталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого,
- в) Бусад холбоотой стандартын шаардлагуудын дагуу тодруулга хийх;

## 4.5. VI YE ШАТ. УУРХАЙГ ХААХ БОЛОН НӨХӨН СЭРГЭЭХ YE ШАТ

### 4.5.1. УЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ:

Нөөцийн шавхагдал эсвэл өөрчлөн байгуулах арга хэмжээ авах болон бусад шалтгаанаар уурхайг хаадаг. Уурхай хаагдах үед ихэвчлэн хаалтын дараах нөхөн сэргээлт, уул уурхайн хог хаягдал зайлцуулах, барилга байгууламжийг нураах, ажилчдад нөхөн олговор олгох, нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэхийг шаарддаг. Мөн уурхай хаагдах үед техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийхээс гадна жил бүр байгаль орчны хяналт, шинжилгээ, мониторингийн ажил хэрэгжүүлдэг. Биологийн нөхөн сэргээлтийн хувьд техникийн нөхөн сэргээлт хийсэн гадаргууд ургамал, ногоо тарих, тогтмол усжуулах, арчилж бордох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлдэг ба техникийн нөхөн сэргээлтийг уурхай дээр ажиллах тоног төхөөрөмжүүдийг ашиглан гүйцэтгэдэг.

### 4.5.2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ:

Аж ахуйн нэгж нь хөрөнгийг олж бэлтгэх, барьж байгуулах, бүтээн байгуулах эсвэл хөрөнгийн энгийн үйл ажиллагааны үед түүнийг ашиглалтаас гаргах үүрэг хариуцлага, мөн хүрээлэн буй орчны хэвийн төрхийг алдагдуулах үед түүнийг нөхөн сэргээлтийн холбоотойгоор гэрээний, хуулийн эсвэл үүсмэл үүрэг хариуцлага үүсдэг. Үүний биелэлтэд зориулж нөөц сан байгуулна.

### 4.5.2.1. УУРХАЙН ХААЛТ БА НӨХӨН СЭРГЭЭЛТЭД ЗОРИУЛАН НӨӨЦ САН БАЙГУУЛАХ

1. НББОУС 37 Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө стандартын дагуу нөөц санг байгуулж бүртгэлд тусгана. Нөөц гэдэг нь цаг хугацаа эсвэл дунгийн хувьд тодорхой бус өр төлбөр юм. Нөөц санг ирээдүйд зардал гарах валютаар байгуулах шаардлагатай.
2. Нөөцөөр хүлээн зөвшөөрөх дүн нь тайлангийн өдрөөрх өнөөгийн үүрэг хариуцлагыг биелүүлэхэд шаардлагатай зарлагын хамгийн сайн тооцоолол байх ёстай. Өрөөр хэлбэл, аж ахуйн нэгж нь тайлангийн өдрөөр тухайн үүргийг биелүүлэх эсвэл зохих ёсоор гуравдагч талд шилжүүлэхийн тулд төлөх дүн байна. Нөөцийг дараах тохиолдолд хүлээн зөвшөөрнө.
  - (i) Өнгөрсөн үйл явдлын үр дүнд өнөөгийн үүрэг хариуцлага (хуулийн дагуу эсвэл үүсмэл) хүлээсэн
  - (ii) Уг үүрэг хариуцлагын төлбөрийг барагдуулахад эдийн засгийн өгөөж бүхий нөөцийн урсгал гарна гэдэг нь магадлалтай болсон
  - (iii) Үүргийн дүнг найдвартай тооцоолох боломжтой
3. Нөөцийг ашиглахдаа тухайн нөөцийг анх хүлээн зөвшөөрөхдөд хүргэсэн зарлагад ашиглана. Хэрэв үүрэг хариуцлагын төлбөрийг барагдуулахад шаардагдах эдийн засгийн өгөөж бүхий нөөцийн урсгал гадагшлах магадлал байхгүй болбол нөөцийн дүнг буцаан бичнэ. Хэрэв нөхөн сэргээлтийн нөөц хүлээн зөвшөөрсөн хөрөнгийг зарсан эсвэл гуравдагч талд шилжүүлсэн тохиолдолд аж ахуйн нэгж нь байгуулсан нөөцийг үл хүлээн зөвшөөрч болно. Мөн гэрээ, хууль эрхзүй ба зарим хуулийн бусад үйл ажиллагаа зэргийн өөрчлөлтийн нөлөөгөөр өмнө нь хүчин төгөлдөр байсан хуулийн болон үүсмэл үүрэг хариуцлага нь үгүй болсон тохиолдолд байгуулсан нөөцийг үл хүлээн зөвшөөрнө.
4. Нөөц санг холбогдох хөрөнгийн өртөгт капиталжуулах ба уурхайн ашиглалтын хугацаанд бүтээгдэхүүний нэгжид, эсвэл шулуун шугамын аргын аль тохиромжтойг сонгон хорогдуулна.

Холбогдох журнаалын бичилт:

(i) Уурхайн хаалт ба нөхөн сэргээлтийн санг анх хүлээн зөвшөөрөхдөө:

Дт: Уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн хөрөнгө .....xxxx

Кт: Уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн сан.....xxxx

(ii) Байгуулсан уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн хөрөнгийг уурхайн ашиглалтын хугацаанд бүтээгдэхүүний нэгжид, эсвэл шулуун шугамын аргын аль тохиромжтойг сонгон хорогдуулна:

Дт: ДҮ .....xxxx

Кт: Уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн хөрөнгө.....xxxx

(iii) Хуулийн дагуу Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансанд мөнгөн хөрөнгийг байршуулсан тохиолдолд барьцааны хөрөнгө, эсвэл урьдчилж төлсөн зардал гэж бүртгэнэ.

#### 4.5.2.2. УУРХАЙН ХААЛТ БА НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН НӨӨЦИЙН ӨӨРЧЛӨЛТ

1. Уурхайн хаалт ба нөхөн сэргээлтийн нөөц сан, хөрөнгийг ашиглалтаас гаргах зардлын нөөц санг анх хүлээн зөвшөөрсний дараа, өр төлбөрийн дансны үнэ нь цаг хугацааны явцад өөрчлөгддөг. Мөн үүрэг хариуцлагыг шийдэхэд зарцуулагдах мөнгөн гүйлгээний дүн болон хугацаа, дискаунтын хувьд орсон өөрчлөлтөөр өр төлбөрийн дүнг тохируулна. Тохируулгыг СТОУСТХ 1 “Хөрөнгийг ашиглалтаас хасах, нөхөн сэргээх болон хүлээсэн байгаа бусад үүргүүдтэй холбоотой өр төлбөрийн өөрчлөлт”-ийн дагуу бүртгэлд тусгана. Нөөц санг тайлант хугацааны эцэс бүрт шалгах ба хамгийн сайн тооцооллоор байх ёстай. Хэрэв тухайн хамгийн сайн тооцоолол нь мэдэгдэхүйц хэмжээгээр өөрчлөгдсөн бол Уурхайн хаалт ба нөхөн сэргээлтийн хөрөнгө –ийн дүнг нэмэгдүүлнэ.
2. Дискаунтын хувь хэмжээ (эсвэл хувь хэмжээнүүд) нь мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн тайлангийн үеийн зах зээлийн үнэлгээ болон тухайн өр төлбөртэй холбоотой эрсдлийг тусгадаг татварын өмнөх хувь хэмжээ байх ёстай. Дискаунтын хувь хэмжээ (эсвэл хувь хэмжээнүүд)-г ирээдүйн мөнгөн гүйлгээний тооцооллоор тохируулсан эрсдлийг тусгах ёсгүй. Дискаунчилал ашиглаж байх үед нөөцийн дансны үнэ нь цаг хугацаа өнгөрөхийн хэрээр тайлангийн үе бүрт өсч/ буурч байдаг. Энэ өсөлтийг зээлийн зардал/санхүүгийн зардал гэж хүлээн зөвшөөрнө.

Холбогдох журналын бичилт:

(i) Дискаунчилал ашиглаж байх үед нөөцийн дансны үнэ нь цаг хугацаа өнгөрөхийн хэрээр тайлангийн үе бүрт өсч/ буурч байдаг. Холбогдох зөрүү дүнгээр санхүүгийн зардал, эсвэл санхүүгийн орлого-г хүлээн зөвшөөрнө.  
Хэрэв өссөн бол:

Дт: Санхүүгийн зардал .....xxxx

Кт: Уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн сан.....xxxx

Хэрэв буурсан бол:

Дт: Уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн сан .....xxxx

Кт: Санхүүгийн орлого.....xxxx

(ii) Аж ахуйн нэгж өмнөх жилүүдэд үүссэн үүрэг хариуцлагыг тухайн жилд нөхөн сэргээсэн бол дараах журналын бичилтийг хийнэ.

Дт: Уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн сан.....xxxx

Кт: Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө, авлага.....xxxx

(iii) Хэрэв аж ахуйн нэгж нь олборлолт хийх явцдаа тухайн газраа тэр дор нь нөхөн сэргээсэн бол холбогдох нөхөн сэргээлтийн зардлыг борлуулсан бүтээгдэхүүний өртөгт бүртгэнэ.

#### 4.5.2.3. УУРХАЙН ХААЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ИТГЭЛЦЛИЙН САН

Уурхайн ирээдүйн хаалт болон байгаль орчны нөхөн сэргээлтийн зардлыг тооцоолсон дүнг төлж барагдуулах зориулалтаар нөхөн сэргээлтийн итгэлцлийн санг байгуулж болно. Ихэвчлэн энэ сан хөрөнгийг бие даасан этгээдэд хариуцуулдаг ба энэ нь хөрөнгө оруулалт юм. Тус сангийн хөрөнгийг СТОУСТХ 5 “Уурхайг ашиглалтаас гаргах болон Байгаль орчны нөхөн сэргээлтэд зориулан үүсгэсэн сангаас ашиглах эрх”-ийн дагуу аж ахуйн нэгж НББ-дээ тусгана. Хэрэв сангийн үйл ажиллагаанд хамтарсан хяналт тавьж байгаа бол хөрөнгө оруулалтын хэмжээг нөхөн сэргээлтэд уг сангаас шаардагдах хөрөнгийн дүн ба тухайн сангийн цэвэр хөрөнгөд аж ахуйн нэгжийн эзлэх хувиар

тогтоосон дүнгийн аль багаар тайлагнана. Хэрвээ уг сан хөрөнгө нөхөн олголтоор бүртгэгдсэн тохиолдолд дэлгэрэнгүй орлогын тайланда санхүүгийн орлого болон зардлаар тусгана. Сангийн хөдөлгөөнийг нь СТОУСТХ 5-аар бус НББОУС 37-ын дагуу хэмжинэ.

#### 4.5.2.4. НӨХӨН ОЛГОВОР

1. Нөөцийн төлбөрийг барагдуулахад шаардагдах зарлагыг бүхэлд нь эсвэл зарим хэсгийг нь гуравдагч талаас нөхөн авахаар (жишээлбэл, даатгалын гэрээ, нөхөн олговортой холбоотой зүйл эсвэл бэлтгэн нийлүүлэгчийн баталгаагаар дамжуулан) хүлээгдэж байгаа үед, хэрэв аж ахуйн нэгж үүрэг хариуцлагынхаа дагуу төлбөрийг барагдуулчихвал нөхөн олговор хүлээн авах нь тодорхой байх нөхцөлд л нөхөн олговрыг хүлээн зөвшөөрнө. Нөхөн олговрыг тусад нь хөрөнгө гэж үзнэ. Нөхөн олговор гэж хүлээн зөвшөөрсөн дүн нь нөөцийн дүнгээс хэтрэх ёсгүй.
2. Аж ахуйн нэгж маргаантай байгаа дүнг бүхэлд нь төлөх хариуцлага хүлээсэн хэвээр байгаа үед гуравдагч тал ямар нэг шалтгаанаар төлбөрөө төлж чадахгүйд хүрвэл төлбөрийн дүнг аж ахуйн нэгж бүрэн барагдуулах ёстай. Энэ нөхцөлд, өр төлбөрийн нийт дүнгээр нөөцийг байгуулах бөгөөд аж ахуйн нэгж өр төлбөрийг барагдуулбал нөхөн олговор хүлээн авах нь тодорхой болно. Энэ үед хүлээгдэж буй нөхөн олговрыг тусад нь хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө.
3. Зарим тохиолдолд, хэрэв гуравдагч тал төлбөрөө төлж чадахгүй үед аж ахуйн нэгж маргаантай байгаа зардлыг төлөх хариуцлага хүлээхгүй байж болно. Энэ үед аж ахуйн нэгж нь тэдгээр зардалтай холбоотой өр төлбөрийг нөөцийн дүнд оруулахгүй.

#### 4.5.2.5. АЖИЛЛАГСДЫН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ

1. Уурхайн хаалтын үед хуулиар хүлээсэн үүрэг болон аж ахуйн нэгжийн практикаас үүсэх аливаа үүсмэл үүргийг (тухайлбал: ажилчдад төлөх төлбөрүүд, ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн төлөвлөгөө, олон тооны ажил олгогчийн төлөвлөгөө) НББОУС 19 Ажилчдын Тэтгэвэр Тэтгэмж стандартын дагуу хүлээн зөвшөөрч тайлагнана. Энэ стандарт нь ирээдүйд төлөх ажилчдын тэтгэвэр, тэтгэмжийн төлөө ажилчид үйлчилгээ үзүүлсэн бол өр төлбөрийг, мөн ажилчдад төлөх тэтгэвэр, тэтгэмжийн хариуд тэдгээрийн үзүүлсэн үйлчилгээнээс бий болох эдийн засгийн өгөөжийг аж ахуйн нэгж зарцуулсан бол зардлыг хүлээн зөвшөөрнө.
2. Олон тооны ажил олгогчийн төлөвлөгөөний хувьд төлөвлөгөөнд оролцдог аж ахуйн нэгж бүр бусад бүх оролцогч аж ахуйн нэгжүүдийн актуар эрсдэлийг хуваалцдаг учраас бусад оролцогч аж ахуйн нэгжид хамаарах актуар гарз; эсвэл бусад аж ахуйн нэгж оролцохоо барьсон үед төлөвлөгөөнд ямар нэгэн дутагдал гарвал түүнийг санхүүжүүлэх тухай төлөвлөгөөний нөхцөлийн дагуу хүлээх аливаа хариуцлага байгаа бол болзошгүй өр төлбөр үүсч болно. Үүнийг НББОУС 37 Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө стандартын дагуу тодруулна.
3. Уурхайн нөөц дуусах нь тодорхой болоход ихэвчлэн орон тооны цомхогтолын зардал нэмэгдэг тул үүнтэй холбоотой орон тооны цомхогтолын үүрэг нь уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн үүрэгтэй ижил байдаг. Мөн аж ахуйн нэгж тэтгэвэрт гарсан ажилчдадаа тодорхой хэмжээний санхүүгийн туслалцаа үзүүлэх үүсмэл хариуцлага хүлээдэг байж болно. Тус хариуцлагыг НББОУС 19 Ажилчдын Тэтгэвэр Тэтгэмж стандартын дагуу хүлээн зөвшөөрч тайлагнана.

#### 4.5.2.6. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН ӨӨРЧЛӨЛТ БА ТООЦООЛЛЫН ӨӨРЧЛӨЛТ

Аж ахуйн нэгж НББОУС 8 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт ба Алдаа стандартын дагуу НББ-ийн бодлого болон тооцооллыг өөрчлөх, өмнөх тайлант үеийн алдааны залруулгыг бүртгэнэ.

4.5.2.6.1. НББ-ийн бодлогын өөрчлөлт – Аж ахуйн нэгж аль нэг СТОУС-аар шаардсаны улмаас эсвэл санхүүгийн байдал, санхүүгийн гүйцэтгэл, мөнгөн гүйлгээнд үзүүлэх ажил гүйлгээ, бусад үйл явдал эсвэл нөхцөл байдлын нөлөөний талаар илүү найдвартай бөгөөд хамааралтай мэдээлэл санхүүгийн тайланд бий болохоор бол НББ-ийн бодлогыг өөрчилнө.

1. Аж ахуйн нэгж НББ-ийн бодлогын өөрчлөлтөд хэрэглэх шилжилтийн тусгай нөхцөлгүй, СТОУС-ыг анх удаа хэрэгжүүлэх эсвэл НББ-ийн бодлогоо сайн дураар өөрчилсний улмаас НББ-ийн бодлогыг өөрчилбөл энэ өөрчлөлтийг өмнөх үе рүү буцаан мөрдөнө. Өмнөх үе рүү буцаан мөрдвөл НББ-ийн шинэ бодлогыг анхнаас нь хэрэглэж байсан мэтээр хамгийн эхний өмнөх тайлант үед толилуулсан өмчийн дансны бүрэлдэхүүн бурийн эхний үлдэгдэл ба өмнөх тайлант үе бүрт тохируулсан бусад зэрэгцүүлэгдэх дүнг тохируулна.

2. Аж ахуйн нэгж НББ-ийн шинэ бодлогыг бүх өмнөх тайлант үед ашигласнаар бий болох хуримтлагдсан нөлөөг тодорхойлж чадахгүй учраас НББ-ийн шинэ бодлогыг өмнөх үе рүү буцаан мөрдөх боломжгүй гэж үзвэл практик боломжтой хамгийн эхний тайлант үеэс эхлэн НББ-ийн бодлогыг гүйцээн мөрдөнө.

3. Бүртгэлийн тооцооллын өөрчлөлт - Аж ахуйн нэгж нь үйл ажиллагааны тодорхойгүй, хоёрдмол байдлаас шалтгаалж санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг нарийн хэмжиж чадахгүй ч зөвхөн тооцоолж болдог. Тооцооллыг хамгийн сүүлийн үеийн бодит, ашиглахад бэлэн байгаа мэдээлэл дээр үндэслэн хийнэ.

4.5.2.6.2. НББ-ийн тооцооллын өөрчлөлт - НББ-ийн тооцооллын өөрчлөлтийн хэмжээгээр хөрөнгө ба өр төлбөрийн дансны үнэ, эсвэл холбогдох эздийн өмчийн зүйлийн дансны үнэ өөрчлөгдөх бөгөөд үүнийг өөрчлөлт гарсан тайлант үед холбогдох хөрөнгө, өр төлбөр буюу өмчийн дансны үнийг тохируулах замаар бүртгэнэ. Үүнээс бусад тооцооллын өөрчлөлтийн нөлөөг тухайн тайлант үед болон хэрэв ирээдүйн тайланд үед нөлөөлөх бол холбогдох тайлант үеүүдэд ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

## ТАВ. ТАЙЛБАР, ЖИШЭЭ

### 5.1. ХАЙГУУЛЫН ӨМНӨХ ТАНДАН СУДАЛГААНЫ ҮЕ ШАТ

а) А компани өмнө нь судлагдаж байгаагүй XXX талбайд ашигт малтмалын нөөц байгаа эсэхийг тогтоох зорилгоор урьдчилсан байдлаар тандалт судалгаа хийж байгаа. Тайлант үед тухайн судалгааны ажилтай холбоотой геологичийн цалин болон геофизикийн анхны туршилт хийлгүүлэхээр гэрээ хийсэн Б туслах компанид төлсөн төлбөр, бусад холбогдох зардлууд тухайлбал машины түрээс, түүнд хийсэн түлш шатахууны зардал гарсан. Компани НББ-ийн бодлогодоо хайгуулын өмнөх тандан судалгааны үе шатанд гарсан зардлыг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ гэж тусгасан. Нягтлан бодогч гарсан зардлыг холбогдох зардлын дансанд бүртгэн Дэлгэрэнгүй орлогын тайлангийн Үйл ажиллагааны зардал хэсэгт тайлагнасан.

Холбогдох журналын бичилт нь:

Дт: Зардлын данс.....xxxxx

Кт: Мөнгөн хөрөнгө/ Өр төлбөр.....xxxxx

б) Ашигт малтмалын нөөцийн урьдчилсан хайгуулын ажлыг хийхэд шаардлагатай тухайн нөөц бүхий газар хүртэл тавьсан замыг НББОУС 16 Үндсэн хөрөнгө-ын дагуу бүртгэлд тусгана.

### 5.2. ХАЙГУУЛЫН БА ҮНЭЛГЭЭНИЙ ҮЕ ШАТ

А компани XXX1 ба XXX2 дугаар бүхий хайгуулын тусгай зөвшөөрлүүд авсан бөгөөд хайгуул ба үнэлгээтэй холбоотой гарсан зардлыг “хөрөнгө”-ийн аргаар бүртгэх тухай нягтлан бодох бүртгэлийн бодлогодоо тусгасан ба удирдлагын шийдвэр гарсан гэвэл дансны бичилт нь;

Холбогдох журналын бичилт нь:

Дт: XXX1 талбайн хайгуул, үнэлгээний хөрөнгө.....xxxxx

Дт: XXX2 талбайн хайгуул, үнэлгээний хөрөнгө.....xxxxx

Кт: Мөнгөн хөрөнгө/ Өр төлбөр.....xxxxx

### 5.3. ХӨРС ХУУЛАЛТЫН ЗАРДЛЫГ КАПИТАЛЖУУЛАХ

Аж ахуйн нэгж нь дараах зардлын мэдээлэл ба олборлолтын мэдээлэлтэй байна.

- 1) Тайлант хугацааны хөрс хуулалттай холбоотой гарсан шууд зардал = 10,000,000ТН
- 2) Хөрс хуулалтын нэмэлт зардал = 2,000,000ТН
- 3) Нийт гарсан хөрс хуулалтын зардал = 12,000ТН
- 4) Тайлант хугацааны хүдрийн олборлолтын хэмжээ – 500 тонн
- 5) Тайлант хугацааны хөрс хуулалтын хэмжээ – 3,000 тонн
- 6) Нийт олборлохоор тооцоолсон хүдэр – 2,300 тонн
- 7) Дээрх тооцоолсон хүдрийг олборлохын тулд тооцоолсон хөрс хуулалтын хэмжээ – 8,000 тонн

1. Тайлант хугацаанд гарсан нийт зардлыг капиталжуулах болон үйлдвэрлэлийн бараа материалд хуваарилах:

- 1) Алхам 1: 1 тонн хүдэр боловсруулахад гарах хөрс хуулалтын харьцааг тооцохдоо = тооцоолсон хүдрийг олборлохын тулд гарах хөрс хуулалтын хаягдалыг / Нийт олборлохоор тооцоолсон хүдэрт харицуулна = 8,000тонн/2,300тонн= 3.48 ( одоогийн уурхайн үе шатны хөрс хуулалтын харьцаа)
- 2) Алхам 2: Тайлант хугацаанд олборлосон хүдэрт ногдох хөрс хуулалтын тооцоолсон хэмжээ = 500тонн\*3.48= 1,740 тонн
- 3) Алхам 3: Тайлант хугацааны хөрс хуулалтын хэмжээ = 3,000 тонн  
Тайлант хугацаанд гарсан нэмэлт хөрс хуулалт= 3,000тонн-1,740тонн= 1,260 тонн

- 4) Алхам 4: Хөрс хуулалтын зардлаас капиталжуулах харьцааг тооцоолох = Тайлант хугацаанд гарсан нэмэлт хөрс хуулалт / (Тайлант хугацааны хөрс хуулалт + Тайлант хугацааны хүдрийн олборлолт) = 1,260тонн / (3,000тонн+ 500тонн)= 36 %
- 5) Алхам 5: Тайлант хугацааны нийт зардлыг капиталжуулах болон уул уурхайн үйлдвэрлэлийн бараа материалд хуваарилах дүнг тодорхойлох  
Капиталжуулах хөрс хуулалтын зардал= 12,000,000TH\*36%= 4,320,000TH  
Бараа материалд хуваарилагдах хөрс хуулалтын зардал = 12,000,000TH-4,360,000TH= 7,640,000TH

## 2. Бүртгэлд тусгах:

- Нийт гарсан зардлын хэмжээгээр Дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэнэ:  
Дт: Дуусаагүй үйлдвэрлэл ..... 12.000.000TH  
Кт: Өр төлбөр/ Мөнгө ..... 12.000.000TH
- Уул уурхайн хөрөнгөнд хуваарилах хөрс хуулалтын зардлын тохируулгын бүртгэл  
Дт: Уул уурхайн хөрөнгө – Хөрс хуулалт ..... 4,320,000TH  
Кт: Дуусаагүй үйлдвэрлэл ..... 4,320,000TH

## 5.4. БАРАА МАТЕРИАЛЫГ ӨРТӨГ БА ЦЭВЭР БОЛОМЖИТ ҮНЭ ЦЭНИЙН АЛЬ БАГААР ҮНЭЛЭХ

А компанийн бараа материалын мэдээлэл:

Бараа	Өртөг	Борлуулах үнэ	Борлуулалтын зардал	ЦБҮЦ	БМ-ын үнэлгээ
A	80TH	135TH	15TH	120TH	80TH
B	90TH	100TH	28TH	72TH	72TH
C	95TH	105TH	13TH	92TH	92TH
Нийт	<b>265TH</b>	<b>340TH</b>	<b>56TH</b>	<b>284TH</b>	<b>244TH</b>

1. ЦБҮЦ-ийг тооцоходоо борлуулах үнээс борлуулалтын зардлыг хасч тооцно.

(i) А барааны хувьд өртөг нь ЦБҮЦ-ээс доош ороогүй тул барааг өртгөөр нь буюу 80TH үнэлнэ. Харин В болон С барааны хувьд өртөг нь ЦБҮЦ-ээс бага болсон тул ЦБҮЦ-ээр үнэлнэ.

Холбогдох журналын бичилт нь:

Дт. БМ-ын үнэ цэнийн бууралтын алдагдал (265TH-244TH) – 21TH

Кт. БМ-ын үнэ цэнийн бууралтын нөөц/ хасагдуулга – 21TH

(ii) Тайлгнал:

Бараа материал 244TH дүнгээр Баланс дээр тусгана.

2.1 Бараа материалын тодруулга:

Бараа материал	265TH
БМ-ын ҮЦБ-ын хасагдуулга	(21TH)
БМ цэвэр дунгээр	244TH

2.2 Дэлгэрэнгүй орлогын тайлан:

Борлуулалтын орлого	450TH
ББӨ	(270TH)
Нийт ашиг	180TH
БМ-ын ҮЦБ-ын зардал	159TH

## 5.5. НӨХӨГДӨХ ДҮНГ ТООЦООЛОХ

Хөрөнгийн дансны үнэ 6,500ТН, бодит үнэ цэнэ 9,000ТН, борлуулахтай холбоотой гарах зардал 2,300ТН.

#### Тооцоолол:

- 4 Борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнэ = 9,000ТН - 2,300ТН = 6,700ТН
- 5 Борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнэ 6,700ТН > Хөрөнгийн дансны үнэ 6,500ТН тул хөрөнгийн үнэ цэнэ буураагүй ба ашиглалтын үнэ цэнийг тооцох шаардлагагүй.
- 6 Хэрэв борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнэ нь хөрөнгийн дансны үнэ цэнээс бага байсан тохиолдолд ашиглалтын үнэ цэнийг тооцоолно.

#### 5.6. АШИГЛАЛТЫН ҮНЭ ЦЭНИЙН ТООЦООЛОЛ

Компанийн удирдлага тухайн хөрөнгийг ашиглахаар тооцсон ирээдүйн 5 жилийн хугацаанд 11,500ТН мөнгө хүлээн авна хэмээн төсөөлсөн.

Жил	Ирээдүйн мөнгөний ургал	Хөнгөлөлтийн хувь 10%	Өнөөгийн үнэ цэнэ
1	3,000	0.909	2,727
2	2,800	0.826	2,314
3	2,500	0.751	1,878
4	2,000	0.683	1,366
5	1,200	0.621	745
<b>Нийт</b>	<b>11,500</b>		<b>9,031</b>

Ирээдүйн мөнгөний ургал: хөрөнгийн ашиглахаар тооцсон үлдсэн хугацааны туршид оршин байх эдийн засгийн нөхцөл байдлын талаарх удирдлагын хамгийн сайн тооцоолол

Хөнгөлөлтийн хувь: энэ хувь нь балансын тайлангийн өдрийн мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн зах зээлийн өнөөгийн үнэлгээнд нөлөөлөх татварын өмнөх хөнгөлөлтийн хувь байна.

#### 5.7. ХӨРӨНГИЙН ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТ

Уул уурхайн компани олборлолт хийж орлого олж байгаа А ба Э гэсэн хоёр уурхайтай (мөнгө бий болгогч нэгж), мөн Б ба Г гэсэн хоёр талбайд хайгуулын ажил хийж байгаа. Б талбайн ашигт малтмалын нөөц харьцангуй бага болохыг тодорхойлсон геологийн судалгаатай удирдлага танилцан уг талбайн хайгуул үнэлгээний хөрөнгөд үнэ цэнийн бууралт хийх буюу өмнө гарсан зардлыг алдагдалд тооцох шийдвэр гаргасан. Энэ нөхцөлд удирдлага нэг бол тухайн хайгуулын ажлын талбайн хэсгийг дангаар авч үзэн зарцуулсан бүх хөрөнгөд бүрэн хэмжээгээр нь бууралт тооцон алдагдал бүртгэнэ. Эсвэл хайгуулын ажил хийж байгаа талбайн хэсгийг олборлолт хийж байгаа хоёр уурхайтай (аль эсвэл нэгтэй нь) нэгтгэн бүлэглэж тэдгээр мөнгө бий болгогч нэгжүүдийн өртөгт хуваарилна. Уул уурхайн үйлдвэрлэлд илүү нийтлэг тохиолддог туршлага бол хайгуулын хэсэг нь уурхайн дэд бүтцийн зориулалттай хөрөнгө эсвэл боловсруулах үйлдвэрийн шууд харьяа талбай байхаас бусад тохиолдолд хайгуулын хөрөнгийг олборлолт хийж байгаа уурхайнуудад шилжүүлэн тооцохгүйгээр хөрөнгийн бууралтыг шууд тооцдог.

#### 5.8. ҮНДСЭН ХӨРӨНГӨД ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТЫГ ТООЦООЛОХ

2015 оны 12 сарын 31-ны байдлаарх хөрөнгийн ашиглалтын үлдэх хугацаа 5 жил, ба хөрөнгийн анхны өртөг 240,000ТН. Хөрөнгийг худалдан авснаас хойши хашалттын нийт хугацаа 7 жил ба компани элэгдлийг шулуун шугамын аргаар байгуулдаг.

Компанийн тухайн хөрөнгийн ирээдүйн 5 жилийн бий болгох мөнгөний орох ургал нь жилийн 50,000ТН (татвараас өмнөх) гэж тооцоолсон ба удирдлага баталсан. Мөн хөрөнгийг ашиглалтын хугацааны эцэст 15,000ТН-ээр борлуулах боломжтой. Энэ төрлийн хөрөнгийн татварын дараах холбогдох хөнгөлөлтийн хувь нь жилийн 14% ба тухайн

жилийн татварын хувь 30%. Хөрөнгийн одоогийн зах зээлийн үнэ 170,000ТН бөгөөд борлуулалтын зардал 15,000ТН.

Дараах байдлаар үнэ цэнийн бууралтын алдагдлыг бүртгэх дүнг тооцоолно.

1. 2015 оны 12 сарын 31-рх нөхөгдөх дүнг тооцно
    - Ашиглалтын үнэ цэнийг тооцох
      - Тооцоолсон цэвэр мөнгөний орж ирэх урсгал= 50,000ТН
      - Ирээдүйд ашиглах хугацаа = 5 жил
      - ХҮҮ= 20% татварын өмнөх (14% x 100/70)
      - Ирээдүйн үнэ цэнэ= 15,000ТН
      - Хөрөнгийн өнөөгийн үнэ цэнэ буюу ашиглалтын үнэ цэнэ нь =155,559ТН ()
    - Хөрөнгийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийг тооцох
      - 170,000ТН- 15,000ТН= 155,000ТН
    - Нөхөгдөх дүнг тооцох
      - борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ ба ашиглалтын үнэ цэнийн аль ихээр илэрхийлэгдэх дүн= 155,559ТН
2. Хөрөнгийн дансны үнийг тооцох (үнэ цэнийн бууралтаас өмнөх)  
240,000ТН- (240,000ТН/7 x 2) = 160,000ТН
  3. 2010 оны 12 сарын 31-рх үнэ цэнийн бууралтын гарзын тооцоолол ба журналын бичилт
    - 2010 оны 12 сарын 31-рх Дансны үнэ = 160,000ТН (тооцоолол 2)
    - 2010 оны 12 сарын 31-рх Нөхөгдөх дүн = 155,559ТН
    - 2010 оны 12 сарын 31-рх үнэ цэнийн бууралтын гарз = 4,441ТН

Холбогдох журналын бичилт:

Дт: Үнэ цэнийн бууралтын гарз .....4,441ТН

Кт: Хуримтлагдсан элэгдэл ..... 4,441ТН
  4. 2015 оны 12 сарын 31-рх Дансны үнэ (үнэ цэнийн бууралтын дараах)  
Дансны үнэ = 160,000ТН- 4,441ТН = 155,559 ТН

## ЗУРГАА. ХАВСРАЛТ

Хайгуул болон Олборлох үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд мөрдөх дансны үлгэрчилсэн жагсаалт нь энэхүү стандартын хамт хэрэглэгдэх баримт бичиг боловч, түүний үндсэн бүрэлдэхүүн хэсэг биш юм.

**A.1 Аж ахуйн нэгж энэхүү журамд заасан дансны кодын эхний хоёр оронг заавал хэрэглэх ба дараагийн оронг өөрийн сонголтоор ашиглах боломжтой.**

Дансны дугаар	Дансны нэр	Тайлбар
	<b>ХӨРӨНГӨ</b>	
	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	
13	Бусад санхүүгийн хөрөнгө	
14	Бараа материал Түүхий нүүрс Борлуулах боломжтой нүүрс Алт Зэс	Аж ахуйн нэгж өөрийн үйлдвэрлэж байгаа бэлэн бүтээгдэхүүн тус бүрээр данс нээж болно
	Бараа материалын Үнэ цэнийн бууралтын нөөц Дуусаагүй үйлдвэрлэл Дуусаагүй үйлдвэрлэл -туслах данс Дуусаагүй үйлдвэрлэл -туслах данс	Сөрөг тохируулгат данс
	Дуусаагүй үйлдвэрлэл -туслах данс	Шууд зардал, Шууд бус зардал, сул зогсолт болон зогсолтын зардал, нуруулдан уусгах зардал тус бүрээр Дуусаагүй үйлдвэрлэлийн туслах данс нээж болно.
	Хүдрийн овоолго	Хүдрийн овоолго, Боловсруулж буй буюу баяжуулах суваг дахь хүдэр гэх мэт нэршлээр данснууд нээж болно
	Хагас боловсруулсан бүтээгдэхүүн Замд яваа бараа, бэлэн бүтээгдэхүүн	
	Сэлбэг хэрэгсэл болон бусад хангамжийн материал	Кэмпийн материал, түлш шатахуун болон бусад материал орно.
	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	
20	Үндсэн хөрөнгө Газрын сайджруулалт Явган хүний зам Хуримтлагдсан элэгдэл Хуримтлагдсан үнэ цэнийн бууралт Бусад газрын сайджруулалт Хуримтлагдсан элэгдэл Хуримтлагдсан үнэ цэнийн бууралт Барилга байгууламж Хуримтлагдсан элэгдэл Хуримтлагдсан үнэ цэнийн бууралт Авто зам Хуримтлагдсан элэгдэл Хуримтлагдсан үнэ цэнийн бууралт Тусгай зориулалттай талбай Хуримтлагдсан элэгдэл Хуримтлагдсан үнэ цэнийн бууралт	
	Гүүр Хуримтлагдсан элэгдэл Хуримтлагдсан үнэ цэнийн бууралт Машин, тоног төхөөрөмж Хуримтлагдсан элэгдэл Хуримтлагдсан үнэ цэнийн бууралт	
	Тээврийн хэрэгсэл	

	Хуримтлагдсан элэгдэл Хуримтлагдсан үнэ цэнийн бууралт Тавилга, эд хогшил Хуримтлагдсан элэгдэл Хуримтлагдсан үнэ цэнийн бууралт Компьютер, дагалдах хэрэгсэл Хуримтлагдсан элэгдэл Хуримтлагдсан үнэ цэнийн бууралт Дуусаагүй барилга Уурхайн хөрөнгө	
21	<i>Биет бус хөрөнгө</i> Техник эдийн засгийн үндэслэл Хуримтлагдсан хорогдол Хуримтлагдсан үнэ цэнийн бууралт Хайгуул Үнэлгээний хөрөнгө Хайгуулын лиценз - XXXX1 Хайгуулын лиценз - XXXX2 Хайгуулын лиценз - XXXX3 Хөгжүүлэлтийн явцад бий болсон биет бус хөрөнгө Хуримтлагдсан хорогдол Хуримтлагдсан үнэ цэнийн бууралт Программ хангамж Хуримтлагдсан хорогдол Хуримтлагдсан үнэ цэнийн бууралт	
22	..... Урт хугацаат хөрөнгө оруулалт	
23	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө Хуримтлагдсан хорогдол Хуримтлагдсан үнэ цэнийн бууралт	
24	Биологийн хөрөнгө	
25	Хойшлогдсон татварын хөрөнгө	
26	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө Хуримтлагдсан элэгдэл Хуримтлагдсан үнэ цэнийн бууралт	
27	Бусад эргэлтийн бус хөрөнгө .....	
<b>ӨР ТӨЛБӨР</b>		
<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
31	Дансны өглөг Туслан гүйцэтгэгчид өгөх өглөг	
32	Урьдчилж орсон орлого	
33	Цалингийн өглөг	
34	Татварын өглөг .....	Роялти болон бусад татварын өглөг
35	Богино хугацаат зээлийн өглөг Хүүгийн өглөг	
36	Ногдол ашигийн өглөг	
37	Нөөц (өр төлбөр) Нөхөн сэргээлтийн нөөц Нөхөн олговрын нөөц	
38	Бусад богино хугацаат өр төлбөр Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн	
39	бус хөрөнгөнд хамаарах өр .....	
<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
40	Урт хугацаат өр төлбөр Урт хугацаат зээл Урт хугацаат нөөц (өр төлбөр)	

	Нөхөн сэргээлтийн нөөц Ажилчдын тэтгэврийн нөөц Тэтгэмжийн нөөц Хойшлогдсон татварын өр төлбөр	
	Бусад урт хугацаат өр төлбөр Өрийн бичиг Холбоотой талд төлөх төлбөр Санхүүгийн түрээсийн өглөг	
	.....	
	<b>ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>	
41	Өмч	
42	Нэмж төлсөн капитал	
43	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	
44	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	
45	Тусгай зориулалтын нөөцийн сангуд	
46	Хуримтлагдсан ашиг, алдагдал	

### A.3 Орлогын тайлангийн дансд

Дансны дугаар	Дансны нэр	Тайлбар
<b>Орлого</b>		
51	Борлуулалтын орлого Роялти	
	Түрээсийн орлого Хүүгийн орлого Ногдол ашгийн орлого Эрхийн шимтгэлийн орлого	
52	Бусад орлого	
53	Гадаад валютын ханшийн зөрүүний олз, гарз	
54	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз, гарз	
55	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз, гарз	
56	Хөрөнгө оруулалт борлуулсны олз, гарз	
57	Бусад ашиг, алдагдал	
60	Борлуулалтын хөнгөлөлт, буцаалт	
<b>Борлуулалтын өртөг</b>		
61	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	
70	<b>Ерөнхий ба удирдлагын зардал</b> Ажиллагчдын цалингийн зардал Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ийн зардал Албан татвар, төлбөр, хураамжийн зардал Томилолтын зардал Бичиг хэргийн зардал Шуудан холбооны зардал Мэргэжлийн үйлчилгээний зардал Сургалтын зардал Сонин сээттуул захиалгын зардал Даатгалын зардал Ашиглалтын зардал Засварын зардал Элэгдэл, хорогдлын зардал Түрээсийн зардал Харуул, хамгааллын зардал Цэвэрлэгээ, үйлчилгээний зардал	

	Тээврийн зардал Шатахууны зардал Хүлээн авалтын зардал Зар сурталчилгааны зардал	
71	Борлуулалт, маркетингийн зардал	
72	Санхүүгийн зардал	
73	Хайгуул үнэлгээний зардал	
74	Бусад зардал	Алданги, торгуулийн зардал, Хандив, тусlamжийн, Найдваргүй авлагын, Хөрөнгө акталж устгасны зардал, Үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын зардал, Болзошгүй өр төлбөрөөс үүссэн гарз, Үнэ цэнийн бууралтын гарз гэх мэт
75	Уурхайн нөхөн сэргээлтийн сангийн бууралт Нөөц шавхагдсан уурхайн хэсэгт ногдох нөхөн сэргээлтийн сангийн өөрчлөлт	
91	Орлогын албан татварын зардал - Тайлант үеийн орлогын албан татварын зардал - Хойшлогдсон татварын зардал	
92	Орлого, зарлагын нэгдсэн данс	

## **ДОЛОО. ТОВЧИЛСОН НЭР ТОМЬЁО**

НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
БҮЦ	Бодит үнэ цэн
БМ	Бараа материал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ДҮ	Дуусаагүй үйлдвэрлэл
ҮНЗ	Үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал
ҮХ	Үндсэн хөрөнгө
ТН	Төлбөрийн нэгж
ШХ	Шууд хөдөлмөр
ШМ	Шууд материал
НББ	Нягтлан Бодох Бүртгэл
НБББ	Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
НББОУСЗ	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл
СТОУСТХ	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Тайлбарын Хороо